

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
“НЭГ ХОТ –НЭГ СТАНДАРТ”

ДЭМБ:

“СУВИЛАГЧ, ЭХ БАРИГЧИЙН ОЛОН УЛСЫН ЖИЛ”

ДҮҮРЭГ:

“ИРГЭДИЙН АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ЖИЛ”

2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БИЧМЭЛ ТАЙЛАН

Тайлант хугацаанд Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв нь Нийслэл болон дүүргийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүн амын эрүүл мэндтэй холбоотой асуудлыг Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоол, шийдвэр дүрэм журмын дагуу шийдвэрлэж ажиллаа.



АЛСЫН ХАРАА:

“Эелдэг харилцаа –Чанартай үйлчилгээ”

ЭРХЭМ ЗОРИЛГО:

“Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг нэмэгдүүлэн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар цогц үйлчилгээтэй манлайлагч эмнэлэг болно”

Тус Эрүүл мэндийн төв нь 2020 онд 230 ор, 17 тасаг нэгжтэй, 319 эмч, эмнэлгийн ажилтантайгаар дүүргийн 5 хорооны 29512 хүн ам, Төв, Хэнтий аймгийн хил залгаа сумдын 30000 орчим хүн амд Эмнэлгийн тусламжийн тухай хууль, Нэгдсэн эмнэлгийн бүтэц орон тооны стандарт MNS5095:2017, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2018 оны 03 дүгээр сарын 28-ны өдрийн “Дүрэм бүтэц батлах тухай” А/44 дугаар тушаалын дагуу нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

“Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”, МУ-ын Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”, МУ-ын засгийн газрын (2016-2020) үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын (2016-2020) үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын (2016-2020) үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэл дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгүүлэх үндсэн чиглэлд тусгасны дагуу дараах ажлуудыг 2020 онд хийж гүйцэтгэсэн.

Нийслэлийн эдийн засаг, нийгэмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 3 заалт, 4 арга хэмжээ, дүүргийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан 4 заалт, 19 арга хэмжээний хэрэгжилтийг тус тус хангах чиглэлээр жилийн ажлаа төлөвлөн гүйцэтгэлийн төлөвлөгөөг нийт **13 чиглэл, 27 зорилтын хүрээнд 51 ажил, төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөний биелэлтийн дундаж хувь 81,4%** байна.

№	Үндсэн чиг үүрэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээ			
				1 ул	2 ул	3 ул	4 ул
1.	Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд	10	15		63,2%		
2	“Нэг хот - Нэг стандарт” хөтөлбөрийн хүрээнд	1	2		75%		
3	Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд	1	3		53,3%		

4	Нийслэлийн Эрүүл мэнд дэд хөтөлбөрийн хүрээнд	2	10		67%		
5	Зорилтот жилийн хүрээнд	3	7		60,7%		
6	Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд	3	4		90%		
7	Архив, албан хэрэг хөтлөлтийн чанар, стандартыг сайжруулах	1	1		100%		
8	Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах	1	1		100%		
9	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах	1	1		100%		
10	Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах	1	1		100%		
11	Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах	1	2		95%		
12	Дүүргийн 40 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд	1	3		55%		
13	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд	1	1		100%		
Нийт		27	51		81,4%		

ХОЁРДУГААР БҮЛЭГ: “ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

Бүтэц үйл ажиллагааны хэрэгжилт:

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв нь 230 ортой /өдрийн 16 ор/, 17 тасаг, нэгжтэйгээр дүүргийн болон Төв, Хэнтий аймгийн ойролцоох сумдын хүн амд нэгдсэн эмнэлгийн бүтэц, орон тооны стандарт MNS 5095:2017-ын дагуу тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Эмчилгээ, оношлогооны стандартын хэрэгжилт: Өвчний түүх бичилт, анхан шатны маягт хөтлөлт, эмчилгээ, оношлогооны стандартад тогтмол хяналт тавин ажиллаж байна. Түгээмэл үйлдлийн стандартын хэрэгжилт:

2019 онд 87,6%

2020 оны 5 сарын байдлаар 86,1%

Коронавирусаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд:

- Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлсэн
- Нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, ариутгалын бодисын нөөцийн агуулахыг тусад нь байгуулсан
- ЭМС-ын 2019 оны 11 сарын 29-ны өдрийн А/536,537,538,539 дүгээр тушаалуудаар ЭМТ, ӨЭМТ-ийн бүх ажилчдад шат дараатай сургалтыг халдвар судлагч эмч зохион байгуулсан. Сургалтанд нийт 213 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.
- Эрүүл мэндийн төвд хэсэгчилсэн хөл хорио тогтоосонтой холбоотой 2020 оны 01 сарын 29-ны өдрөөс эхлэн хэвтэн эмчлүүлэх тасагт эмчлүүлж буй /халдвартаас бусад/ өвчтөнүүдийн эргэлтийг эмнэлгийн ажилтнууд тасаг, нэгжид хүргэж эхэлсэн.
- Амбулаториор үйлчлүүлэгчдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор утсаар /70212905/ цаг олгон, бүх үйлчлүүлэгчдийн халууныг хэмжиж, спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгчээр үйлчлүүлэгч бүрийн гарыг халдваргүйтгэж байна.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг халдвараас хамгаалж, дархлааг дэмжих зорилгоор аарц, аньсны шүүс, Норов-7 тантай шөл өгсөн.
- Эрүүл мэндийн төвийн тасаг нэгжүүдийн бэлэн байдлыг хангаж, мөн халдвартын тасагт коронавируст халдвар /COVID-19/-тай өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлэх шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган бэлэн байдалд ажиллаж байна. Халдвартын тасгийн амьсгалын хэсэгт вакум хаалт хийж халдвартай бүсийг тогтоосон.
- Сэжигтэй 2 тохиолдол, нэг удаагийн үзүүлэх сургуулилтанд оролцож ажилласан.



Цэвэрлэгээ, үйлчилгээний стандартын хэрэгжилт, “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент”-ийн чиглэлээр:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тав тухтай орчинд үзүүлэх нөхцөл боломжийг хангах, цэвэрлэгээний чанарыг стандартын түвшинд байлгаж дотоод халдвар гаргахгүй ажилласан. Цэвэрлэгээний чанар өмнөх онтой харьцуулахад 8% хувиар өсөж, 96% -д хүрсэн. MNS5095:2017 стандарт, ЭМС-ын 169,187, 505 тоот тушаалын дагуу давхардсан тоогоор 85 ажилтанд 339 удаа хяналт тавин цэвэрлэгээ үйлчилгээ, халдвар хамгаалал, ёс зүйн санал гомдол гаргалгүй ажилласан.

ЭМС-ын 505 тоот тушаалын заавраар шинэчлэн гаргаж, түүний дагуу бүртгэн мэдээ тайланг сар бүр ХӨСҮТ-д мэдээллэн ажиллаж байна. Үүнд:

- ❖ Халдвартай хог хаягдал – 5967,6 кг
- ❖ Хурц үзүүртэй иртэй хог хаягдал- 1731,6 кг
- ❖ Эмгэг хог хаягдал- 281,7 кг
- ❖ Эмийн болон эсэд хортой хог хаягдал- 17 кг
- ❖ Химийн хог хаягдал- 6,4 кг

- ❖ Эмийн болон химийн бодисийн хог хаягдал 23 кг-ийг цуглуулж “Элемент” ХХК-тай гэрээ хийж, гэрээний дагуу зөөвөрлөн устгасан.

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн сувилахуйн алба нь удирдах дээд байгууллага, мэргэжлийн нийгэмлэгүүдээс сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр 12 тушаал шийдвэр, албан тоот хүлээн авч хэрэгжилтийг хангах зорилгоор ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Үүнд:

- НЭМГ-ын даргын 2020-04-15 өдрийн А/41 тоот “Сувилахуй эх барихуйн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тушаалын дагуу 3 зорилтын хүрээнд 9 ажил хийхээр төлөвлөгөө гарган холбогдох удирдамж журмыг байгууллагын даргаар баталгаажуулан гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна Энэ чиглэлээр хийхээр төлөвлөсөн ажлын биелэлт 45%- тай байна.

- ЭМС-ын 2020 -02-27 өдрийн А/139 тоот “Сувилахуй эх барихуйн чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” тушаалын хэрэгжилтийг хангахаар байгууллагын төлөвлөгөөнд 4 ажил тусгасанаас биелэлт 50% байна

- НЭМГ-ын даргын 2020-04-01 өдрийн А/32 тоот “Хүүхдийн эндэглийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тушаал

- НЭМГ-ын 2020-05-13 өдрийн 8/331 албан тоот УГТЭ “Сувилагч мэргэжилтний хөгжил-2020” сэдэвт үндэсний хэмжээний цахим сургалтанд хамрагдах тухай

- ЭМС-ын 2020-01-22 өдрийн “Шинэ корона вирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах тухай” 19 тоот албан даалгавар

- ЭМЯ, ЗӨСҮТ-ийн 2020-01-28 өдрийн “Зөвлөмж хүргүүлэх” 15/45 албан тоот

- НЭМГ- даргын 2020-02-14 өдрийн “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжих тухай” А/15 тоот тушаал

- ЭМС-ын 2020-02-18 өдрийн “Коронавируст халдвар COYID-19-ын үед эмнэлгийн тусламж үзүүлэх зураглал батлах тухай А/101 тоот тушаал

- ХӨСҮТ-даргын Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийх зааварчилгаа

- ЭМС 2020-03-10 өдрийн COYID-19-ын үед хамгаалах хувцас хэрэгслийг зохистой хэрэглэх Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмж

- ЭМС-ын 2020-4-29 өдрийн Коронавирус covid-19-ын тандалт сэргийлэлтийн түр заавар шинэчлэн батлах тухай А/ 269 тоот тушаал зэргийг нийт сувилагч тусгай мэргэжилтнүүдэд танилцуулан эмчилгээ чанар, халдвар хяналт, аж ахуй үйлчилгээний албадуудтай хамтран төлөвлөгөө гарган сургалт зохион байгуулж үр дүнг тооцон ажиллаж байна.

- ЭМС-ын 611 тоот тушаал, ЭМС-ын 536, 537, 538, 539 тоот тушаалуудын холбогдох заалт хаврсалтуудыг үйл ажилагаандаа хэрэгжүүлэн мөрдөж ажиллаж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ:
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1 НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ:

А. Нийгмийн эрүүл мэндийн салбар хоорондын хамтын ажиллагаа

2020 оны эхний хагас жилд коронавируст /ковид-19/ халдварын нөхцөл байдлаас уялдан Нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгаа, уулзалт, зөвлөгөөн, мэдээ, мэдээллийг “ЦАХИМ” хэлбэрээр зохион байгуулж ажилласан.

Дүүргийн НЭМСЗөвлөлтэй нийт 52 байгууллагын Facebook хуудсаар Ёовид-19- тэй холбоотой болон эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгаа хүрч байна.

Мөн дүүргийн орон нутгийн “Сүлжээ-3 телевиз, FM 104.5 радиогоор цаг үеийн мэдээ, мэдээлэл, сургалт, өдөрлөгийн үйл ажиллагаа, эрүүл мэндийн зөвлөгөөг 64 удаа хүргэн ажиллалаа.

Мэдээллийн самбар байгууллагын утгах хэсгийн LED дэлгэцэнд болон 12346 дагагч бүхий Багануур дүүргийн Засаг даргын тамгын газрын Facebook хуудас болон 4998 дагагч бүхий Нийгмийн эрүүл мэндийн төвийн Facebook хуудас, 1456 дагагчтай “Сүрьеэгүй дүүрэг” Facebook хуудас болон дүүргийн таван хороо, дөрвөн ӨЭМТ-ийн Facebook хуудсаар дамжуулан COVID-19 халдварын талаарх мэдээ, мэдээллийг өдөр тутам байршуулан ажиллаж байна. Мөн 70959 хандалт бүхий www.bnemn.ub.gov.mn Багануур Эрүүл мэндийн төвийн веб сайтад НЭМТ-ийн үйл ажиллагаа, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг байршуулан иргэдэд цахим эрүүл мэндийн боловсрол олгохоор ажиллаж байна. Байгууллагын цахим хуудсанд 15 мэдээ, фэйсбүүк хуудсанд 62 мэдээ, мэдээллийг оруулсан байна.



Б. Зохион байгуулсан өдөрлөг, аян, хөдөлгөөн

2020 оны 1, 2 сард “Хором бүрээ анхааръя”, “Осол гэмтлээс сэргийлье” аяныг амжилттай зохион байгууллаа. Тэмдэглэлт өдрийн хүрээнд дүүргийн ЕБС, цэцэрлэгийн нийт 11 эмч нарт “Осол гэмтлээс урьдчилан сэргийлье”, “Бага насны хүүхдийн осол гэмтэл, түүнээс урьдчилан




сэргийлье” сэдвээр сургалтыг зохион байгуулан дүүргийн ЕБС, цэцэрлэгүүдийн хүүхэд, сурагчид болон эцэг эх, асран халамжлагч нарт хийх сургалтыг эрчимжүүлэн ажиллахаар төлөвлөн хийсэн боловч сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хаасантай холбогдуулан сургалтын үйл ажиллагааг хойшлуулаад байна. Энэхүү аяны хүрээнд дүүргийн 19 БААН-үүд, хороодын 1120 ажилтан, албан хаагчид болон иргэдийг сургалт, сурталчилгаанд хамруулан, 892 ширхэг нарын авлага зөвлөмжийг хүргэн ажиллалаа. Дүүргийн “Сүлжээ-3” телевизээр гэмтлийн эмч н.Мөнхсүх иргэдэд осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, авах арга хэмжээний талаарх эрүүл мэндийн зөвлөмж, мэдээллийг хүргэлээ. ЭМТ, ӨЭМТ-дийн цахим хуудсаар **“Осол, гэмтлээс урьдчилан сэргийлье”** сэдвийн хүрээнд эрүүл мэндийн зөвлөмж, сэрэмжлүүлгийг 2 сарын турш явуулсан.

Дүүргийн ЭМТ, ОБХ, Цагдаагийн хэлтэс, ГБХЗХХ хамтран 4-р хорооны “бага насны хүүхэд хамгаалал ба осол гэмтлээс урьдчилан сэргийлье” сэдвийн хүрээнд хамтарсан багийн арга хэмжээг зохион байгуулсан.

Дүүргийн бага насны хүүхэдтэй эрсдэлт бүлгийн судалгааг хороо тус бүрээр гаргуулан ЭМТ, ОБХ, Цагдаагийн хэлтэс, ГБХЗХХ-ийн мэргэжилтнүүд хамтран дүүргийн 4-р хорооны 18 айл өрхөөр хамтарсан шалгалтыг зохион байгуулан, бага насны хүүхдийн осол гэмтэл болон хүчирхийлэл, гэмт хэрэгт өртөх эрсдэл, галын аюулгүй байдал, хараа хяналт, орчны аюулгүй байдал зэргийг үнэлэн, эцэг эх, асран халамжлагч нарт зөвлөгөө, зааварчилгааг өгч, ““Осол, гэмтлээс урьдчилан сэргийлье”, “Шинэ коронавирусын халдвараас сэргийлье”, “Галыг аюулгүй байдал”, “Хүүхдийн аюулгүй байдал” сэдвийн хүрээнд 129 ширхэг эрүүл мэндийн зөвлөмж, мэдээлэл, сэрэмжлүүлгийг хүргэн ажиллалаа. Цаашид дүүргийн 4 хороодын эрсдэл бүлгийн айл өрхөөр хяналт, шалгалтыг хийн зөрчил, дутагдлыг арилгуулан ажиллахаар төлөвлөөд байна. Мөн хамтарсан багын гишүүд тус бүр чиглэлийн дагуу гарын авлага, зөвлөмж, маск, гар ариутгагчийг айл өрхүүдэд тараалаа.



“ТАМХИГҮЙ” уриан дор зохион байгуулсан дэлхийн тамхигүй өдрийг угтсан үйл ажиллагаа. 2020 оны 05 дугаар сарын 31-ны өдрийг “ТАМХИГҮЙ” уриан дор тэмдэглэхээр болсон бөгөөд ЭМТ, ӨЭМТ-үүд дэлхийн тамхигүй өдрийн хүрээнд тамхи болон электрон тамхины хор хөнөөл, дам тамхидалтын хор хөнөөлийн талаар иргэдэд өгөх зөвлөгөө мэдээллийг Эрүүл мэндийн төвийн болон ӨЭМТ-ийн Facebook page дээр орууллаа. 72 хүн like дарж 11 хүн share хийсэн байна.



Мөн тамхи, дам тамхидалтын хор уршгийн талаар ухуулга, зурагт хуудсыг НЭМҮТ-ийн цахим хаягнаас татан авч байгууллагын мэдээллийн самбарууд болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчиллаа.

Тамхины хор хөнөөлийн талаарх зурагт хуудас болон тамхи татахыг хориглосон тэмдэг, тэмдэглэгээ бүхий ухуулах хуудсыг



БААН-н өрөө тасалгаа, орох гарах хэсгийн хаалганд байршуулсан.



Хорооны БААН-ийн хаалган дээр тамхи татахыг хориглоно гэсэн тэмдэглэгээг наасан.

[Smoke Free Mongolia](#) facebook хуудсыг БААН, олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулж, “Та ч бас чадна” уриалгад нэгдсэн.

Эрчүүд олноор ажилладаг байгууллага болох БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨҮГ, ЗӨБЦДҮС-ТӨХК, ЗӨБЦТҮС-ТӨХК, БАГАНУУР УУРХАЙН дотоод сүлжээ, ажилчдын хаалттай группт [Smoke Free Mongolia](#) facebook хуудсанд байрлах зөвлөгөө, мэдээллийг байршуулсан. Мөн орон нутгийн Сүлжээ-3 телевизээр дамжуулан иргэдэд тамхинаас гарах зөвлөгөө, мэдээллийг БНЭМТ-ийн сэтгэц, наркологийн эмч, зүрх судасны эмч нар өглөө.



Тамхинаас татгалзах зургаан “З”-ийн арга, Тамхины хор хөнөөл сэдэвт зөвлөмж, гарын авлага тарааж нийт 83 иргэнд сурталчилгааг хүргэж, 42 тамхины хамааралтай иргэдээс тамхины хамаарлыг илрүүлэх, тамхи татахад нөлөөлөх хүчин зүйлийг судлах зорилгоор асуумж судалгаа авч үр дүнг тооцон ажиллалаа. Нийт судалгаанд оролцсон иргэдээс 35/83,3% нь эрэгтэй, 7/16,7% нь эмэгтэй байсан бөгөөд насны бүлгээр нь авч үзэхэд 18-20 насны 3/7,1%, 21-35 насны

10/23,8%, 36-49 насны 9/21,4%, 50с дээш насны тамхи татдаг 20/47,6%-ийг эзэлж байна. Гэр бүлийн хүн нь хамт тамхи татдаг 7/16,7%-ийг эзэлсэн. Дам тамхидалтанд хаана өртөж байна гэсэн асуумжинд ажлын байранд 19/57,6%, олон нийтийн газар 7/21,2%, гэртээ 7/21,1%-ийг, тамхи татахад нөлөөлөх хүчин зүйлс Архи уухад тамхи татдаг гэсэн 18/54,5%, найз нөхөд уруу татдаг 20/60,6%-ийг эзэлж байгаа нь тамхины хэрэглээ архи уухад, найз нөхөдтэйгөө уулзахад их байдаг нь ажиглагдаж байна.

“Коронавирус /Ковид-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд: 23 байгууллагын нийт 3976 ажилчдад “ТТТӨ ба шинэ коронавирусээс сэргийлье” сэдвээр сургалт зохион байгуулж, гарын авлага, гар ариутгагч, гарын саван өгсөн. Мөн ЭМТ-өөр үйлчлүүлэгчид болон хэвтэн эмчлүүлэгчид болон хороодын иргэдэд “ТТТӨ ба шинэ коронавирусээс сэргийлье” сэдвээр нийт 13 удаагийн сургалт, мэдээлэл өгч нийт 206 хүнийг хамруулсан. 2992 ширхэг сурталчилгааны материал, зөвлөмж тараан, 900 ширхэг постер, 32 ширхэг гар ариутгагч, халдварт өвчнөөс сэргийлэх ширээний календарь тараалаа. Дүүргийн “Сүлжээ-3” телевизээр “ТТТӨ ба Шинэ коронавирусээс сэргийлье” сэдвээр 4 удаа хүүхдийн ерөнхий мэргэжилтэн, ерөнхий эмч, халдвар судлагч нар мэдээлэл, сэрэмжлүүлгийг хүргэн ажиллалаа.

ЭМТ, ӨЭМТ-дийн эмч нарт 10 удаа 297 эмч нарт /давхардсан тоо/ “Шинэ коронавирусын өвчний үед баримтлан ажиллах тушаал, түр заавар, мэдээлэл”-ийг танилцуулсан байна.

ЭМТ-ийн халдвар хяналтын тасгаас “Шинэ коронавирусын халдварын үеийн сэргийлэлт ба хяналт” сэдвээр ахлах сувилагч-14 /2020.01.24/, эмч-31 /2020.02.07/, ЭМТ, ӨЭМТ-дийн тасгийн эрхлэгч, ахлагч нар-9 /2020.02.17/ нийт 54 ажилчдад сургалтыг зохион байгууллаа.

ЭМТ-ийн халдвар хяналтын тасаг, Нийслэлийн Зооноз өвчин судлалын төвөөс 2 удаагийн “Хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөж, тайлах” онол ба дадлага, сургалтыг зохион байгууллаа. НЗӨСТ-өөс 2020 оны III/16-20-ны өдөр нийт 7 удаа сургалт зохион байгуулахад эмч 29, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн-115, жолооч-3, үйлчилгээний ажилтан-31 нийт 178 ажилтнуудыг сургалтанд хамрууллаа.



ЭМС-ын А/135 тоот тушаал, “Шинэ коронавирусын халдвар” сэдэвт сургалтанд эмч-73 /2020.03.06/, 2020.03.23-ны өдөр сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд-102, ААТ-ын 49 /халдваргүйтгэл/ нийт 224 ажилтнуудад сургалт зохион байгуулсан байна.

Багануур дүүргийн ЭМТ-ийн Чанарын албаны дарга Ц.Балжидмаа, Эрчимт эмчилгээний эмч Г.Батбаатар, Халдвар судлагч эмч О.Очмаа, Г.Хишигсүрэн, Сувилахуйн албаны дарга Б.Оролмаа нар 2020.03.19-ний өдөр Эрүүл мэндийн Хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Шинэ коронавирусын халдварын эмчилгээ оношилгоо, халдварын сэргийлэлт хяналт, халдваргүйтгэлийн үйл ажиллагаа

болон хүн амд үзүүлэх сэтгэл зүйн тусламж” сэдвээр хийсэн сургалтанд сууж, 2020.03.23-24-ны өдрүүдэд дээрх сэдвээр ЭМТ-ийн нийт 73 эмч, 102 сувилагч, 49 үйлчлэгч, ажилчдад сургалтыг хийлээ. Сургалтанд нийт-224 хүн хамрагдсан байна.

“Шинэкоронавирусын халдвараас урьдчилан сэргийлье” сэдэвт постер, гарын авлага: НЭМГ-аас А3 постер 5 төрөл 500 ширхэг, А5 хэмжээтэй зөвлөмж 5 төрөл 380 ширхэгийг нийт 880 ширхэг постер, гарын авлагыг хүлээн авч тараасан.

В. Эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ

“Эрүүл иргэн 2020” аяны нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

2020 оны 01 сарын 23-ны өдөр 11:30 цагаас НЭМТ-д “Эрүүл иргэн 2020” аяны хүрээнд НЭМТ, ӨЭМТ-үүд хамтран халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлэх үзлэг, оношлогоо, шинжилгээг зохион байгуулж, “Тэмбүүг устгая” аяны талаарх мэдээлэл, аяны хүрээнд зохион байгуулах урьдчилан сэргийлэх үзлэгийн хуваарийг БААН-үүдэд танилцууллаа. Уг арга хэмжээг



Дүүргийн засаг дарга Ц.Сандаг-Очир нээж үг хэлсэн бөгөөд “БЗДХӨ, Тэмбүү өвчний өнөөгийн байдал, урьдчилан сэргийлэх арга замууд” сэдвээр ДОХ, БЗДХӨ кабинетийн их эмч Л.Мөнхбаяр, “ТТТӨ-өөс сэргийлэх нь” сэдвээр ЭЭОД Сэлэнгэсүлжээ сургалт, мэдээлэл хийлээ. Уг арга хэмжээнд нийт 29 байгууллагын 137 ажилчид, НЭМСЗ-ийн гишүүд хамрагдлаа. Зохион байгуулсан оношлогоо, шинжилгээ:



- Элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээ – 24 хүнд хийж 2 хүн В вирус илэрсэн.
- Хавдарын маркер – 42 хүнд үзсэн
- Хелико бактерийн шинжилгээнд – 32 хүн хамрагдсан
- Тэмбүү өвчин илрүүлэх түргэвчилсэн тестийн оношлогоонд – 15 хүн
- 137 хүнд гарын авлага тарааж, 342 ширхэг бэлгэвч тараасан байна.

“Тэмбүүг устгая” аян: Дүүргийн хэмжээнд 18-45 насны 11605 иргэдээс зорилтот бүлгийн нийт 3369 иргэд Тэмбүүгийн оношлогоонд хамрагдана. Үүнээс ӨЭМТ-ийн харьяалалаар үзэхэд:

- 1-р өрхийн эмнэлэг нийт 18-45 нас иргэн 2482 үүнээс зорилтот бүлэг 127
- 3-р хороо 18-45 нас 3678 иргэнээс зорилтот бүлгийн 1035
- 4-р хороо 18-45 нас 2379 иргэнээс зорилтот бүлгийн 674
- 5-р хороо 3066 иргэнээс зорилтот бүлгийн 1533

Оношлогоо, шинжилгээний хамрагдалт, хавьтал илрүүлгийн хувийг нэмэгдүүлэх чиглэлээр: “Тэмбүүг устгая” аяны ажлыг эрчимжүүлэх зорилгоор 4 ӨЭМТ-үүдийн нутаг дэвсгэрт харьяалагдах хороо болон БААН-үүдийн 18-45 насны ажилчдыг сонгон ЭМТ-ийн даргын батлагдсан хуваарийн дагуу түргэвчилсэн тестээр оношилгоог хийж байна.

ӨЭМТ-үүдийн хийсэн оношилгоо:

- Энэрэлт-Өлзий -336
 - Биваангирд -587
 - Энх-Өрх -522
 - Ач-Элбэрэл -204
 - ЭМТ-ийн ДОХ, БЗДХӨ кабинетаар 2083 нийт 3732 иргэд 5-р сарын 30-ны байдлаар хамрагдаад байна.
1. Шинээр нийт оношилогдсон тэмбүү 21, үүнээс жирэмсэн 5, хавьтал эмчилгээнд бүрэн хамрагдсан 3 тун хийгдсэн.
 2. Дүүргийн хэмжээнд зохион байгуулсан архины хамааралтай 20 иргэнд тэмбүүгийн түргэвчилсэн тестээр оношилоход хуучин 2 онош батлагдсан.
 3. ХӨСҮТ-д сар бүрийн 15, 30-нд тэмбүүгийн мэдээг хүргэн ажиллаж байна.
 4. Иргэдэд бэлгийн замаар дамжих халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх, ЭМ-ийн зөвлөгөө, зөвлөмж өгөх зорилгоор цахим фэйсбүүк хуудсаар 11 зурган зөвлөмж, санамжуудыг, 4 видео бичлэгийг байршуулсан байна.

ХБӨ-ний эрт илрүүлгийн үзлэг: Жил бүр ӨЭМТ-үүд дээр Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт шаардагдах хөрөнгийн зардлын судалгааг гаргуулан Засаг даргын нөөцөөс санхүүжүүлдэг уламжлалтай.

Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг 2020 оны 05-р сарын 31-ны байдлаар:

- Хөхний өмөн өвчний эрт илрүүлэг -7565 хамрагдахаас 2550 буюу 33,7%,
- Умайн хүзүүний өмөн өвчний эрт илрүүлэг-1894 хамрагдахаас 1013 буюу 53,5 %
- “Эрүүл зүрх-Эрүүл Монгол” хөтөлбөрийн хүрээнд артерийн даралт ихсэх, өвчний эрт илрүүлэг -18609 хамрагдахаас 5133 буюу 27,6%, идэвхитэй хяналтын хувь 12%-тай байна.
- Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг -18609 хамрагдахаас 5101 буюу 27,4% тус тус хамрагдсан байна.

“Элэг бүтэн – Монгол” вирус илрүүлэг шинжилгээ: “Элэг бүтэн-Монгол” хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгийнхэнд вирус илрүүлэх шинжилгээг ӨЭМТ-үүд дээр зохион байгуулж 2020 оны 05 сарын 31-ны байдлаар 763 хамрагдахаас 268 буюу 35,1% хамрагдсан бөгөөд В вирус - 90 хүнд, С вирус - 108 хүнд илэрсэн байна.

“Элэг бүтэн-Монгол” хөтөлбөрийн хүрээнд ЭМТ-ийн ажилчид болон ӨЭМТ-ийн ажилчдад вирус илрүүлэх шинжилгээг хийсэн ба нийт 67 эмч, эмнэлгийн ажилчдад В гепатитийн шинжилгээ хийгдэж, 2 ажилчинд В гепатит илэрч, 65 ажилчдад В гепатитийн 3 тунт вакцины 2 тун хийгдсэн байна.

Мөн 2020 оны эхний хагас жилийн байдлаар заавал хийх дархлаажуулалт болох В гепатитийн дархлаажуулалтын хамрагдалтын хувь –99,2%, А гепатитийн хамрагдалтын хувь - 93,4%-тай байна.

“Эрүүл шүд - Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөр: Багануур дүүрэгт 2015 онд Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулагдсан бөгөөд 2017 оноос эхлэн Нүүр амны эрүүл ахуйч ажиллан амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт сурталчилгааг хийж байна. Шүдний кабинетэд 2019 оноос Нүүр амны эрүүл ахуйч ажиллаж 1446 иргэдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж хүн тус бүрд зөвлөгөө өгч ажиллаж байна.

- Шүдний кабинетийн нийт үзлэг- 11009 (100%)
- Амбулаторийн үзлэг -9021 (81.9%)
- Урьдчилан сэргийлэх үзлэг-1988 (18.1%)
- Анх-5749 (63,7%)
- Давтан-3272 (36,3%), байна.

Амны хөндийн сургалт сурталчилгааг ЕБС-ийн сурагч, цэцэрлэгийн хүүхэд, эцэг эх асран хамгаалагч, тасагт хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгдэд, аж ахуй нэгж байгууллагын ажилчин албан хаагчдад тогтмол хийдэг. 2020 оны хагас жилийн байдлаар амны хөндийн эрүүл мэндийн сургалтыг дараах сэдвүүдээр нийт 211 хийсэн Үүнд :

- | | | |
|--|---|---------------|
| <ol style="list-style-type: none"> 1. Шүдний сойз зөв сонгох арга-48 хүнд 2. Хүүхдийн шүд угаах арга аргачлал-3 (эцэг эхчүүдэд) 3. Шүд угаах арга аргачлал-66 хүнд зөвлөгөө 4. Хооллолтын зөвлөгөө-3 ээжид 5. Bruxism-н зөвлөгөө-1 хүнд 6. Хүүхдийн шүд цоорох өвчин түүнээс урьдчилан сэргийлэх арга -38 хүнд 7. Шүдний өнгөр,чулуу түүнээс у/с аргууд-9 хүнд 8. Шүдний тулгуур эдийн өвчин түүнээс у/с аргууд-43 хүнд (Багануур-Ус) | } | ганцаарчилсан |
|--|---|---------------|

Урьдчилан сэргийлэх сийлант-4 хүүхдэд, цоорлыг удаашруулах түрхлэг-30 хүүхдэд, фторт лак-127 хүнд түрхэж, шүдний өнгөлгөө-8 хүнд, шүдний өнгөр тодорхойлж шүд угаалтыг заах-9 хүүхдэд, 198 хүний шүдний чулууг цэвэрлэж шүдний тулгуур эдийн өвчлөлөөс сэргийлэх арга хэмжээ авч ажиллаа.

Шүдний кабинетээр үйлчлүүлж байгаа хүүхэд болон насанд хүрэгчдэд амны хөндийн эрүүл мэндийн чиглэлийн зөвлөмж мэдээг зурагтаар дамжуулан видео бичлэг, шторкоор хүргэж байна. Мөн шүдний өнгөр тодорхойлох цомгийг үйлчилгээндээ нэвтрүүлэн шаардлагатай хүүхдүүдэд шүдний өнгөөр тодорхойлж шүд угаах аргыг зааж байна.

Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

Д/д	Шалгуур үзүүлэлт	Хүрсэн түвшин			
		2017	2018 он	2019 он	2020 он
1.	5-6 настай хүүхдийн дунд шүд цоорлын тархалтын хувь	86,1%	88,3%	89,5%	88.8%
2.	12 настай хүүхдийн дунд шүд цоорлын тархалтын хувь	86,2%	89,0%	88%	87.5%
3.	5-6 настай хүүхдийн дунд шүд	6,4	7,0%	7,5%	7,4%

	цоорлын эрчим (ЦЛ/шүд)				
4.	12 настай хүүхдийн дунд шүд цоорлын эрчим (ЦЛА/шүд)	6,1	6,8	6,9%	6,7%
5.	Бэлтгэгдсэн нүүр амны эрүүл ахуйчийн тоо	63	1	1	1
6.	Шүдний эрүүл ахуйн төлөвлөгөөт үзлэгт хамрагдсан хувь	0	15,6%	41.2%	18.1%

Зорилтот бүлгийн иргэдэд зохион байгуулсан эрт илрүүлэг үзлэг: Багануур дүүргийн засаг даргын 2020 оны 04 сарын 16-ны өдрийн А/149 тоот захирамжийн хүрээнд зорилтот бүлгийн иргэд (тэнэмэл амьдралтай, архины хамааралтай, хог түүдэг зэрэг иргэд) –ийг 3 хоног амралтын газар байрлуулан, дараах цогц тусламж үйлчилгээг үзүүлээ. Үүнд:

- Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ
- Эмчилгээ */ЭМТ-өөс 24 цагийн турш тогтмол эмч байрлуулан ажиллаж, шаардлагатай эмчилгээ, үйлчилгээг хүргэсэн/*
- Хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх
- Иргэний бүртгэл, баримт бичигтэй болгох
- Дүүргийн “Гэгээ” “Нөхөрлөл” АА цуглааныхантай 14 хоногт 1 удаа очиж уулзан цаг авч мэдрэмж тайлах, 12 алхам, 12 уламжлалаар ярилцлага зохион байгуулж байна. 7 хүнийг шинээр АА цуглаанд оруулж, архины дур дарах эмийн эмчилгээ хийн хянаж, нийгэмшүүлэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн үзлэгт архины хамааралтай нийт 30 хүн хамрагдаж дараах өвчлөл илэрсэн.

- Дотор, зүрх судас: Элэгний хатууралтай 2 хүн, элэгний архаг хордлогот үрэвсэлтэй 3 хүн, ходоодны архаг үрэвсэлтэй 1, II зэрэг II үе шатны артерийн даралт ихэсдэг хүн 6, Зүрхний хэм алдагдалтай /Брадикардия/ -1 хүн, өөх тосны солилцооны алдагдалтай – 2 хүн, ИБС /ишеми болон стенокарди/ -1 хүн, архаг бронхит- 1 хүн, Биж хам шинжтэй -2 хүн, Гиперхолестеринемия /цусан дахь холестерин ихдэлт -1, САГ – 1, Токсический гепатит -1 хүн байна.
- Сүрьеэ: кат/ангинатай 1 хүн байна.
- Арьс, харшил: Хэт нөсөөжих эмгэг-1, Кожный зуд-1 , Атопич/дерматит-1 , аллер/ринит -2, зулгарсан шархлаа -2, гарын зүсэгдсэн шархлаа -1, шивээстэй -1,
- Мэдрэл: Хүчдэлийн толгойн өвдөлт -2, Гэмтлийн гаралтай толгойн өвдөлт -4, нойргүйдэл -1, Судасны шалтгаант толгойн өвдөлт -1, Бүсэлхий ууцны эмгэг -6, Тархины хагалгааны дараах уналт таталт -1, тархины харвалтын үлдэц-1, Тархины судасны нарийсал -1, архины шалтгаант толгойн өвдөлт -1,
- Эмэгтэйчүүд: Вагинит -1, вагинит + ВМС -1
- Сэтгэц: архины хордлого -2, F10.3 - 5, G40 -1, F10.3, F10.3, F10 – 1, Гастрит -1
 Үзлэгээр: 1-2 хавсарсан эмгэгтэй- 9 хүн, 3-4 хавсарсан эмгэгтэй 21 хүн байсан бөгөөд ямар ч өвчин эмгэггүй, эрүүл хүн байхгүй байсан.

Шинжилгээгээр: Элэгний В вирустэй – 3 хүн, Элэгний С вирустэй – 2 хүн байна. Тэмбүүгийн шинжилгээгээр эерэг хариу гарсан -1 хүн байна.

Эмчилгээнд сэтгэц нөлөөт тайвшруулах эмчилгээг давхардсан тоогоор- 22 хүнд, даралт бууруулах эмчилгээг- 9 хүнд, өвдөлт намдаах эмчилгээг- 4 хүнд, хордлого тайлах эмчилгээг- 7 хүнд, бусад эмчилгээг -4 хүнд нийт эмчилгээнд 103,500₮ зарцууллаа. Шинжилгээнд нийт ЭМТ-ийн лабораториос цусны дэлгэрэнгүй шинжилгээ, биохимийн шинжилгээнд нийт 30 хүнийг хамруулж, ЦДШ-270,000₮, БХШ-553.500 нийт ЭМТ-өөс лабораторийн шинжилгээнд 823,500₮ зарцуулсан байна. ӨЭМТ-үүд сахар, тэмбүү, элэгний В,С вирусын шинжилгээг нийт 30 хүнд хийж, сахар-78,000₮, тэмбүүгийн оношилгоонд 162,000₮, элэгний В,С вирусын оношилгоонд 210,000₮ нийт 450,000₮-ийг ӨЭМТ-өөс гаргаж санхүүжүүлсэн.

“Сүрьеэгүй дүүрэг” дэд хөтөлбөр: Сүрьеэ өвчний өвчлөлийг эрт үед илрүүлэх, үзлэг, оношилгоог чанартай хүртээмжтэй үзүүлэх зорилгоор 2019 оноос эхлэн дүүргийн БААН-үүд болон хорооны иргэдэд үзлэг, оношилгоог төлөвлөгөөний дагуу хийсээр байна. 2020 оны эхний хагас жилд Ковид -19 халдвараас шалтгаалан үзлэгийн хамрагдалт бага байна.

- 2020 он 5-р сарын 30-ны байдлаар 5 байгууллагын 288 ажилтаныг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулаад байна.
- Сүрьеэгийн эрсдлийн асуумж судалгааг нийт 28 байгууллагын 1260 иргэд, ажилтан албан хаагчдын хамруулан дүгнэн ажиллаж байна. Цаашид үйлчилгээний байгууллагын ажилчдын хамруулахаар төлөвлөөд байна.
- Сүрьеэгийн эмчийн хяналтанд эмчлэгдсэн болон эмчлэгдэж байгаа 16 иргэдийн амжиргааны түвшинг судлан, 4 хорооны нийгмийн ажилтанд албан бичгээр хамтран ажиллах хүсэлт илгээж, харьяаны хяналтын иргэдийн амьдралтын түвшинг дахин судлаж, халамж үйлчилгээнд хамруулах боломжийг бүрдүүлэх ажлыг хийж байна.
- Иргэдэд “Сүрьеэгүй дүүрэг” нэртэй 2506 найзтай фэйсбүүк хуудсаар сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношилгоо, үзлэгт хамрагдах ЭМ-ийн зааварыг байршуулан ажиллаж байнаад бөгөөд сүрьеэ өвчний талаар нийт 28 удаагийн зөвлөмж, 7 видео бичлэгийн байршуулаад байна.
- Дүүргийн хэмжээнд зохион байгуулсан архины хамааралтай 20 иргэнд Сүрьеэгийн илрүүлэгийн үлэгийг хийхэд сүрьеэ илрээгүй.

2020 оны хагас жилийн байдлаар Сүрьеэгийн кабинетын нийт үзлэг-2446, урьдчилан сэргийлэх үзлэг - 2359, урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь-96% байна.

СҮРЬЕЭ ӨВЧИНД АНХААРАЛ ХАНДУУЛАХ

Цаг нь болсон...

- Сүрьеэгийн талаар ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭХ ЦАГ НЬ БОЛСОН!
- Сүрьеэг устгахад МАНЛАЙЛАХ ЦАГ НЬ БОЛСОН!
- Сүрьеэг устгахад нэгэн хүчээр ХАМТРАН ЗҮТГЭХ ЦАГ НЬ БОЛСОН!
- Өөрсдийн эгцээ ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАХ ЦАГ НЬ БОЛСОН! (олон нийтийн ойлгоны) КАРГОСООР ДАХИУН СҮРЬЕЭГ УСТАХААДУУ ХОЛГОНОНТЭГЭЭЭ!

СҮРЬЕЭГИЙН ШИНЖ ТЭМДЭГ

- Цустай дэр гарах
- Халуурал
- Цэцэрлэг олох
- Жин бурах
- Шөнө зогсох
- 14 хоног буюу гүүрээс дунд хугацааг ханилгах
- Ховоно дуршиж бурах
- Ядарч сулдах

Бүр хэл амьдралын сүрьеэ өвчлөх 13% нь өвчлөх бэлдэ

Хүрээ танд эзгүх шинж тэмдэг үзвэрлэ дургийн эргүүд мэдэгийн төвийн сүрьеэгийн лаборатори үзвэрлэ хандыг

Таны ойр дотны хэл нэгэн сүрьеэгээр өвчлөх бол 0-15 насны хүүхдүүд арьсны сорилд (туберкулеза), 15-с дээш насныхан шинжлэг роготон зүүр, сорил шинжилгээнд хамрагдахг эрвэлж байна.

СҮРЬЕЭ ӨВЧНӨӨС ХАМТДАА УРЬДЧИЛАН СЭРГИЙЛБЭ

СҮРЬЕЭ ӨВЧНӨӨС ӨВЧНИЙ ХАМТДАА ХАМРАГАХ АМ

Халдвартай хамтрахыг сүрьеэгийн өвчлөх өвч, өвчлөх, шалгах, бүрэн үзэх сүрьеэгийн өвч агаар тийшдэг зүүр хэл халдвар гаргах

Халдвартай хамтрахыг сүрьеэгийн 1 хүн жилд 10-15 хувь халдвар гаргах

СҮРЬЕЭ ӨВЧНӨӨС ӨВЧНИЙ ХАМТДАА ХАМРАГАХ АМ

СҮРЬЕЭ ӨВЧНӨӨС ӨВЧНИЙ ХАМТДАА ХАМРАГАХ АМ

СҮРЬЕЭ ӨВЧНӨӨС ӨВЧНИЙ ХАМТДАА ХАМРАГАХ АМ

СҮРЬЕЭ ӨВЧНӨӨС ӨВЧНИЙ ХАМТДАА ХАМРАГАХ АМ

Сүрьеэгээр ХЭН Ч өвдөх эрсдэлтэй

Нийгмийн Эрүү

Багануур Сүрьеэгүй Дүүрэг

Add to Story View As Edit Profile More

Сүрьеэгийн эрсдлийн судалгааг 23 ААН, байгууллагуудын ажилчдаас сүрьеэгийн эрсдэлийн асуумж авч дүгнэлт хийж ажиллав.

Сүрьеэгийн кабинет тоон үзүүлэлт

Үйл ажиллагааны үзүүлэлт		2-р улирал
Шинээр илэрсэн болон дахилттай өвчин	Шинээр илэрсэн уушгины сүрьеэ	6
	Шинээр илэрсэн уушгины бус эрхтэний сүрьеэ	1
	Үүнээс 0-14 насны хүүхэд уушгины	0
	0-14 насны хүүхэд уушгины бус эрхтэний	0
	Дохилт	1
	Шилжиж ирсэн	0
Хяналтанд байгаа	Уушигны сүрьеэтэй	10
	Уушигны бус эрхтэний сүрьеэ	4
	Хавьтагсад нийт	21
	0-14 насны хүүхэд	13
	Хэт өндөр урвалтай	0
	Үүнээс эмийн эмчилгээнд хамрагдсан хүүхэд	0

ХДХВ, бэлгийн замаар дамжих халдвар: 2020 оны хагас жилийн байдлаар БЗДХӨ-ний кабинетын амбулаторын үзлэг-2264, урьдчилан сэргийлэх үзлэг - 2083, урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь-87% байна.

ДОХ/БЗДХ кабинетын үндсэн үзүүлэлт /2020 оны эхний хагас жил/

1. БЗДХ-ын өвчлөл

№	Өвчлөл	2016	2017	2018	2019	2020
1	Тэмбүү	35	20	34	23	16
2	Заг хүйтэн	43	29	40	33	51
3	Трихомониад	23	22	18	13	11
4	Кандид	9	-	8	4	2
5	Кондилом	3	2	-	1	-
6	Бэлгийн хомхой	1	4	6	5	2

2. БЗДХ-ын өвчлөл /10000 хүн амд/

№	Он	2017		2018		2019		2020	
		Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд
1	Тэмбүү	20	6,9	34	11,7	23	7,9	16	5,5
2	Заг хүйтэн	29	10,0	40	13,8	33	11,3	51	17,5
3	Трихомониад	22	7,5	18	6,2	13	4,4	11	3,7
4	Кандид			8	2,7	4	1,3	2	0,6
5	Кондилом	2	0,6	-	-	1	0,3	-	-
6	бусад	4	1,3		2,0	5	1,7	2	0,6
	БҮГД	77	26,5	106	36,7	79	27,2	82	28,2

Хүүхэд өсвөр үеийн эрүүл мэнд: Өсвөр үеийн кабинет нь ӨЭМТ-ийн болон ЕБС-ийн эмч нартай хамтран ЭМ-ийн чиглэлээр мэдээлэл сургалт хийх, урьдчилан сэргийлэх үзлэг хийж зөвлөгөө өгөх, эрсдэлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдэд ганцаарчилсан зөвлөгөө өгөх, гэр бүлд нь холбон зуучлах зэргээр ажиллаж байна.

2020 оны хагас жилийн байдлаар өсвөр үеийнхэнд хийсэн нийт үзлэг 736, урьдчилан сэргийлэх үзлэг- 11 буюу 1,52%, Ганцаарчилсан зөвлөгөө өгсөн өсвөр насны хүүхэд-181, Сургалтанд хамрагдсан хүний тоо-2 удаа 96 хүн хамрагдсан байна.

Хүүхдийн тусламж үйлчилгээний хяналт үнэлгээг тогтмолжуулан, хүүхдийн эрүүл мэндийн судалгаануудыг хийж дүгнэлттэй ажиллахад:

- дүүргийн нийт өсвөр насны хүүхдийн тоо 4441 /10-18нас/
- сургуульд сурдаг 6050
- хөдөлмөр эрхэлдэг 21/ унаач хүүхэд/
- сургууль завсардсан 1 /аутизм 4-р ангиас/
- хэвтрийн 14
- нэн ядуу 1253
- жин багатай 106
- илүүдэл жинтэй 291
- таргалалттай 66
- өсөлт хоцорсон 85
- хагас өнчин 163
- бүтэн өнчин 16
- айлд суудаг 419
- эмзэг бүлгийн /Эрсдэлт / 121 байна.

2020 оны хагас жилийн байдлаар ЭМТ-ийн хүүхдийн тасагт 473 хүүхэд хэвтэн эмчлүүлсний 65 нь өсвөр насныхан эзэлж байна. Охидын төрөлт нийт төрөлтийн 5.3%-г эзэлж байна. Өсвөр үеийнхний бэлгийн замаар дамжих халдвараар өвдөж оношлогдсон байдал 2020 оны хагас жилийн байдлаар нийт тохиолдлын 18.3%-г эзэлж байна. ЕБС-д суралцаж байгаа нийт 86 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.

Сэтгэц, наркологийн тусламж үйлчилгээ: 2020 оны эхний хагас жилд амбулаторит нийт 2581 үзлэг хийснээс өвчний учир амбулаториор 385, урьдчилан сэргийлэх үзлэг 2195 буюу урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 85 % байна.

- Сэтгэцийн хурц өөрчлөлттэй 4 хүнийг стационарт хэвтүүлэн эмчилж ремиссийн байдалд оруулсан.
- Сэтгэцийн эмч нь сэтгэцийн өвчний хурц догшролтой 8 хүнийг ар гэр болон цагдаагийн тусламжтай СЭМҮТ-д хүргэн эмчилгээнд оруулсан.
- Архины хордлого тайлах Өдрийн эмчилгээнд 6 хүнийг эмчилгээнд оруулан диспансерын хяналтанд авсан.
- 2020 оны эхний хагас жилийн байдлаар сэтгэцийн кабинетын хяналтанд байх 21 хүний групп сунгаж, 3 хүнийг группд шинээр оруулж, 31 хүнд

нейролептик эмийг үнэгүй олгохоор ЭЧХК-н хурлаар оруулж шийдвэрлүүлсэн.

- Сэтгэцийн эмч нь 2020 оны эхний хагас жилийн байдлаар Дүүргийн Цагдаагийн Хэлтэсээс шинжээч эмчээр томилсон томилгооны дагуу 4 хүнд сэтгэцийн тусгай үзлэг, шинжилгээ хийж дүгнэлтийг гарган мөрдөн байцаагчид заасан хугацаанд нь хүргэн ажиллав.
- Өсвөр үеийн 3 хүүхдэд 5 удаагийн үзлэг, ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөлгөөг өгсөн.

Дархлаажуулалт: 2020 оны хагас жилийн байдлаар заавал хийх дархлаажуулалтанд халдварт саа-97,2%, Тавт-96,7%, Гепатит А-93,4%, УГУ-93,1%, Гепатит В-99,2%, ПЭВ-94,6% хамрагдсан. Дархлаажуулалтын нэгжүүдийн үйл ажиллагаанд, хүйтэн хэлхээний горимыг чанд мөрдөн ажиллаж байгаа эсэхэд халдвар судлагч тогтмол хяналт тавьж ажилласан.

Вакцин биобэлдмэлийн нөөц, хангамжийн VSSM 4.7 программыг 2019 оны 1 сараас эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.

3.2 ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

А. Эмчилгээ, үйлчилгээний чиглэлээр

НЭМГ-ын даргын 2019 оны “Эмнэлгийн тусламж, үйлчилгээг шинэчлэн зохион байгуулах, өргөжүүлэх тухай” А/59 тоот тушаалын дагуу **2019 онд мэс засал, гэмтлийн тусламж үйлчилгээг орон нутагт хөгжүүлэх** зорилгоор Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 115 сая.төг бүхий С-РАМ гэмтлийн мэс заслын үеийн дижитал рентген аппарат, дунд чөмөгний гэмтлийн ком багаж, доод мөчний гэмтлийн ком багаж, шилбэний гэмтлийн ком багаж, дээд мөчний гэмтлийн ком багажнуудтай болсоны үр дүнд 2019 онд гэмтлийн 18 төрлийн 64 удаагийн мэс заслыг амжилттай хийсэн бол 2020 онд **Шархны халдвартай үйлчлүүлэгчийг тусгаарлах өрөөг шинээр тохижуулан байгуулж, мэс заслын тасгийг ЭХО аппаратаар ханган**, эмч, сувилагчийн ажлын ачааллыг бууруулж, яаралтай үеийн оношлогооны хугацааг хэмнэх боломжийг бүрдүүлээд байна.

2020 онд нүүр амны мэс заслын эмчээр хангагдсаны үр дүнд

- Эвэрхий нөхөх мэс засал
- Шүдний бүх төрлийн буглаа нээх, бусад мэс ажилбарыг шинээр нэвтрүүлэн хийж эхлээд байна.

Тайлант хугацаанд гэмтлийн 19 төрлийн 35 мэс заслыг орон нутгийн түвшинд хийж үйлчлээд байна.

Энэ нь тусламж үйлчилгээг иргэдэд цаг алдахгүй үзүүлэх, УБ хот руу явах урсгалыг багасгах, үйлчлүүлэгчдийн цаг хугацаа, эдийн засгийг хэмнэх зэрэг ач холбогдолтой иргэдийн талархал хүлээсэн үйлчилгээ болоод байна.


Шинээр хийгдэж буй гэмтлийн мэс заслууд:

1. Дунд чөмөгний хугарлыг ил аргаар ялтас шургаар бэхлэх мэс засал
2. Шилбэний хугарлыг хагас ил аргаар түгжээт хадаасаар бэхлэх мэс засал
3. Шивнүүрийн хугарал ил аргаар бэхлэх мэс засал
4. Сорви чөлөөлж, арьс нөхөх мэс засал

5. Гарын хуруу болон хөлийн борвины шөрмөс залгах хагалгаа
6. Гадна хавчаар ясны хугарлыг /шагай/ ил аргаар бэхлэх мэс засал
7. Шууны хугарлыг ил аргаар ялтас шургаар бэхлэх мэс засал
8. Шилбэнээс хадаас авах мэс засал
9. Шуунаас уян хадаас авах мэс засал
10. Гарын долоовор хурууны тэнийлгэгч шөрмөс залгах мэс засал
11. Борвины шөрмөс залгах мэс засал
12. Шагайн үений хагас мултралыг засч, гадна хавчаар ясны хугарлыг ил аргаар эвлүүлж ялтас шургаар бэхлэх мэс засал
13. Шаант ясны доод булууны үе дайрсан хоёрлосон хугарал, гадна хавчаар ясны зөрөөтэй хугарлыг ил аргаар эвлүүлж ялтас шургаар бэхлэх мэс засал
14. Хүүхдийн шуу, богтос ясны гандан хэсгийн хавсарсан хугарлыг рентген харалтын доор эвлүүлж, далд аргаар уян хадаасаар бэхлэх мэс засал
15. Эгэмний сэлтэрч зөрсөн хугарлыг ил аргаар эвлүүлж ялтас шургаар бэхлэх мэс засал
16. Өвдөгний үе солих мэс засал
17. Дунд чөмөгний хугарлыг рентген харалтын дор эвлүүлж, түгжээт хадаасаар бэхлэх мэс засал
18. Цээж, хэвлийн гэмтлийн үеийн мэс засал
19. Түнхний үе солих мэс засал

Анатомын бүрэн бүтэн байдлыг богино хугацаанд сэргээж, хагалгааны дараахь 1 дэх өдрөөс хөдөлгөөн хийх боломжтой болох бөгөөд хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг 50%-иар бууруулан, эмнэлгийн ор хоногийг 4-5 хоногоор бууруулж чадсан.

Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг буюу 3-р шатлалын эмнэлэгийн ачааллыг багасгасан, дүүргийн иргэдийнхээ орон нутагтаа эмчлүүлэх бололцоог бий болгон тусламж үйлчилгээний нэр төрөл олширч, эмч нарын мэргэжлийн ур чадвар дээшилж, санхүүгийн хэмнэлтийг бий болгож байна.



Мэдээгүйжүүлгийн их эмч Г.Азбаяр, мэс заслын их эмч Б.Батзаяа нар хүүхдийн мэдээгүйжүүлэг, мэс заслаар төрөлжсөн нарийн мэргэжил олгох сургалтанд хамрагдан төгсч, 2019 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хүүхдийн мэс заслын багажтай болсны үр дүнд **хүүхдийн мэдээгүйжүүлэг, хүүхдийн мэс заслыг орон нутагтаа** хийх боломж бүрдсэн бөгөөд 2019 онд 10 хүртлэх насны хүүхдэд тохиолдсон 5



төрлийн 64 мэс засал, 2020 онд 8 төрлийн 74 удаагийн мэс засал, нийт 138 удаагийн мэс заслыг орон нутагтаа амжилттай хийгээд байна. Үүнд:

- Цавины ивэрхий, цавины ивэрхийг Mesh буюу тор тавьж нөхөх хагалгаа
- Фимоз
- Гэдэсний үхжилт үрэвсэл
- Гэдэсний түгжрэл
- Хүйсний ивэрхий
- Төмсөг буулгах
- Мухар олгой
- Нарийн гэдэснээс гадны биет авах зэрэг мэс заслуудыг хийгээд байна.

Эрүү нүүрний мэс заслыг орон нутагтаа хийж, үйлчлүүлэгчийг дээд шатлалын эмнэлэг рүү илгээх урсгал чирэгдлийг багасгасан. Шүдний гаралтай буглаа нээх 58, хэлний хөвч уртасгах 15, буйлан доторх хөндлөн ургасан шүд ба буйлны киста 15 тус тус ерөнхий болон хэсгийн мэдээ алдуулалт дор хийж гүйцэтгэсэн. Хүндрэлтэй шүд авах тусламж үйлчилгээг 20 хүнд үзүүлсэн.

Гемодиализ эмчилгээ: Тайлант хугацаанд 3ш аппарат, 15 үйлчлүүлэгчид нийт 598 сеанс эмчилгээний хүрээнд 37.315.2л цусыг цэвэршүүлж ажилласан. Гемодиализ эмчилгээний үеийн эрсдлийн бэлэн байдлыг хангах зорилгоор 3 оронд ханын хүчилтөрөгч байршуулсан.

Өдрийн хими эмчилгээ хийхээс гадна 48 цагийн хими эмчилгээг орон нутагтаа хийж байна. Хавдрын эсрэг өвөрмөц эмчилгээ болох хими эмчилгээг УБ хот, Хавдар судлалын үндэсний төвд очин хийлгэдэг байсан бол 2017 оны 06 дугаар сарын 14-ны өдрөөс орон нутагтаа хийж эхлэн.

- 2017 онд 3 хүн 2 назологиар схемийн дагуу 15 удаагийн өдрийн хими эмчилгээ
- 2018 онд 16 хүнд 7 назологиар схемийн дагуу 63 удаагийн өдрийн хими эмчилгээ, 48 цагийн хими эмчилгээг нэмэгдүүлэн нэвтрүүлж 1 хүнд схемийн дагуу 11 удаагийн эмчилгээ
- 2019 онд 56 удаагийн хими эмчилгээ нийт 27 хүнд 8 төрлийн өвчний назологиар хийсэн. Үүнээс 13 удаа 48 цагийн хими эмчилгээ
- Тайлант хугацаанд /2020 оны эхний 5 сар/ 7 назологиор нийт 19 удаагийн өдрийн хими эмчилгээ, 4 удаагийн 48 цагийн хими эмчилгээг хийж үйлчилсэн.

Хими эмчилгээнд хамрагдагсдын өвчний назологын байдал 2017 онд өндгөвч, хөхний хавдар, 2018 оноос ходоод, улаан хоолой, давсаг, умайн хүзүү, хамар залгиур, 2019 онд уушгины хавдарын үеийн хими эмчилгээнүүд тус тус нэмэгдсэн бөгөөд 2020 оноос **химийн 2 дах шатны шинэ нэр төрлийн эмчилгээг эмчилгээндээ нэвтрүүлээд** байна.

2017 оны 05 сараас хойш 3 дах жилдээ тасралтгүй хийх хугацаанд хими эмчилгээнд орсон бүх эмчлүүлэгч нар дахилт, сэдрэл өгөөгүй, хүндрэл гараагүй байгаа нь эмчилгээний үр дүн сайн болохыг харуулж байна.

“Жирэмсний хяналт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэг цэгийн үйлчилгээ”-г

ЭМТ-ийн амбулаторийн нэг давхарт байгуулан, жирэмсний зөвөлгөө өгөх кабинет, жирэмсний доторын кабинет, жирэмсний ЭХО болон лабораторийн шинжилгээ, сургалт сурталчилгаа, дугаар олголтын хэсгийг нэг цэгт төвлөрүүлсэн. Ингэснээр жирэмсэн эх, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэг дороос хүлээгдэл чирэгдэлгүй, чанар хүртээмжтэй, ээлтэй орчинд цогц байдлаар үзүүлэх нөхцөл бүрдэж байгаа юм. Уг нэг цагийн үйлчилгээгээр тайлант хугацаанд жирэмсний хяналтанд 263 эмэгтэй орсноос 225 эмэгтэй эрт хугацаандаа хамрагдаж, жирэмсний эрт илрүүлэлт 85,1 хувьтай байна. Эрхтэн тогтолцооны эмгэгтэй 62 эмэгтэйг бүртгэн авч, эмчилгээнд хамруулж байгаа бөгөөд эрүүлжилт 87,1 хувь. Төрөх тасагт эрхтэн тогтолцооны эмгэгтэй 86 жирэмсэн эхчүүдийг хэвтүүлэн эмчилсэн. Жирэмсний пренаталь оношлогоонд рисктэй 14 эхийг хамруулсан. TORCH шинжилгээнд 11 эхийг хамруулж, архаг халдвартай 9 эх эмчилгээнд хамрагдсан. Онцгой хяналтанд 48 эхийг авч хянаж байгаагаас ЭХЭМҮТ-д 7 эхийг шилжүүлэн төрөлтийг шийдвэрлүүлсэн.



2020.04.01-ээс эхлэн жирэмсний дотрын эмгэгийн кабинетийг шинээр нээж ажиллуулсан. Тус кабинет нь 328 жирэмсэн эхчүүдэд оношлогоо, үзлэг хийсэн ба дээд шатлалын эмнэлэгт 3 эхийг илгээж, оношийг тодруулсан. Дотрын эмгэгтэй 18 жирэмсэн эхчүүдийг тасагт

хэвтүүлэн эмчилсэн.

Хөнгөвчлөх эмчилгээний тусламж үйлчилгээг НЭМГ-ын даргын 2017 оны а/0 тушаалаар Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний орыг дотрын хөнгөвчлөх эмчилгээний 4, хавдарын үеийн хөнгөвчлөх эмчилгээний 4, нийт 8 ортойгоор ажиллаж байна. Хөнгөвчлөх эмчилгээний тасаг нь тайлант хугацаанд нарийн мэргэжлийн 1 их эмч, хөнгөвчлөх эмчилгээний өдрийн 1 сувилагчтайгаар 101 хүнийг хэвтүүлэн эмчилж үйлчилсэн байна.

Хэт авиан оношилгооны тусламжтайгаар төвийн венийн судсанд гуурс тавих ажилбарыг нэвтрүүлсэн. Уг ажилбарыг нэвтрүүлснээр үйлчлүүлэгчид аюулгүй, эрсдэлгүй, хүндрэлгүй /олон дахин хатгагдах, зэргэлдээх эрхтэн, артер хатгагдах, цус алдах зэрэг/ тусламж үйлчилгээ үзүүлж байна.



Угтах, цахим үйлчилгээ иргэдэд улам ойртсоор:

Дүүргийн иргэд өөрийн харьяа ӨЭМТ-өөсөө дүүргийн ЭМТ-ийн нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэх цаг авах боломжийг бүрдүүлсэн ба УНТЭ-тэй харилцан хамтран ажиллах хэлэлцээр байгуулсны үр дүнд дүүргийн ЭМТ-өөс 13а маягтаар УНТЭ-ийн нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэх цагаа авах боломжтой болж үйлчлүүлэгчдийн чирэгдлийг багасгасан.

Амбулаторийн хэсгийн 2 жигүүрт 4 хөтөч сувилагчийг тогтмол ажиллуулж

- Шинжилгээний бар кодыг шууд олгох
- Үйлчлүүлэгчдийн артерийн даралт үзэж, пульс тоолох
- Биеийн жингийн индекс тодорхойлох
- Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт хийх зэрэг сувилахуйн тусламжийг үзүүлэн ажилласнаар иргэдэд үйлчилгээ ойртуулж, төвлөрлийг сааруулж байна.



Коронавирусийн халдвараас сэргийлэх, сэрэмжлүүлэх зорилгоор үйлчлүүлэгчдийн хоорондын зайг 1 метрээс дотогш байлгахгүй үүднээс цахим хэсэг, өлгүүр, тасалбар авах, гадна хүлээлгийн фасад, давхаруудын коридорид “Сэрэмжлүүлэг” тэмдэг тэмдэглээ наасан.

2016-2017 онд ЭМСХХ-5 төслийн хүрээнд **Цусны салбар банк**ийг **өргөжүүлэх төслийн хүрээнд** нийт 51 нэр төрлийн 72 ширхэг 732950031,31₮ нийт тоног төхөөрөмж, тавилга, багаж, хэрэгсэл, урвалж бодис, 50 сая.төг-ний байрны засвар үйлчилгээ хийгдэж, сүүлийн үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангагдсаны үр дүнд 4-6 нэр төрлийн цус цусан бүтээгдэхүүнийг 1-3 цагийн хугацаанд орон нутагтаа үйлдвэрлэн, эмчилгээ үйлчилгээнд хэрэглэж байна. Үүний үр дүнд:

- Цус цусан бүтээгдэхүүнийг
- Яаралтай үеийн бэлэн байдал хангагдсан.

Цусны салбар банк нь жилд дундажаар 200 орчим донороос бүхэл цус цуглуулж 100000 орчим мл 400 орчим нэгж 4-6 нэр төрлийн цус цусан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, хэрэглэж байна.

Тайлант хугацаанд 34989 мл буюу 149 нэгж цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглээд байна.

2018-2019онд ЭМСХХ-5 төслийн хүрээнд:

- **хог хаягдалын менежментийг сайжруулах** 1,725,487,400₮,
- **микробиологийн лабораторийн үйл ажиллагааг сайжруулах** 3,927,532,143.99₮,
- **эмнэлгийн ариутгалын менежментийг сайжруулах** 6,847,156,674.24₮, нийт 12,721,537,756.23₮-ний санхүүжилт бүхий төсөл хэрэгжиж байгаа бөгөөд 2019 оны 06 сарын 01-ны өдрөөс микробиологийн лаборатори, 2019

оны 08 сарын 01-ны өдрөөс төвлөрсөн ариутгалын хэсэг тус тус ажиллаж эхэлсэн.

Үүний үр дүнд:

- Үйлчлүүлэгчид, иргэдийн антибиотик тэсвэржилт буурах
- Сүүлийн жилүүдэд антибиотикийн хэрэглээ, зөв сонголтонд эерэгээр нөлөө үзүүлэх
- Эмнэлгийн дотоод халдварыг тандах судлах сэргийлэх үйл ажиллагаа сайжирах
- Эмнэлгийн халдвар хамгааллын дэглэм сайжирч, эрсдэл буурах зэрэг өндөр ач холбогдолуудтай.



2020 оны эхний 5 сарын байдлаар төвлөрсөн ариутгал нийт 704.1459 багаж, 70666 бикс, 173 гадны бикс 46-г ариутгасан байна.



ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар ОХУ-д үйлдвэрлэгдсэн ВФЭ2/0.9 маркын Нэг удаагийн оролтонд 35 кг зөөлөн эдлэлийг ариутгах хүчин чадал бүхий 17,060,000 төгрөгийн дезкамерыг суурилуулж 2019.10.15-аас ашиглаж эхэлсэн бөгөөд тайлант хугацаанд дотоод халдваргүйтгэлийг 334,863 м2 талбайг хлорсептын 0,03% уусмалаар хийж халдваргүйжүүлэн, 5790 кг зөөлөн эдлэл дезкамерт ариутгасан.

Уураар мананцар үүсгэж ариутгагчтай болж айл, өрх, албан байгууллагын урьдчилан сэргийлэх болон голомтийн ариутгалыг хийж гүйцэтгэж байна.



“МЭДРЭЛ, УЛАМЖЛАЛТ, СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСАГ”:

Үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээ, эмчилгээ оношлогооны практикт тулгуурлан уламжлалт анагаах ухаан болон европ эмчилгээний үр дүнтэй аргуудыг цогц байдлаар хослуулан эмчлэх “МЭДРЭЛ, УЛАМЖЛАЛТ, СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСАГ”-ийг 26 ортойгоор 2018.02.01-ны өдрөөс нээн ажиллуулж эхэлсэн бол 2019 онд 8 ор нэмж 34 ортойгоор үйл ажиллагаагаа өргөжүүлэн 2018

онд 1290 хүн, 2019 онд 1192 хүн 8275 ор хоног, 2020 оны эхний 5 сард 593 хүн 4269 ор хоног ашиглан хэвтэн эмчлүүлээд байна.

Мэдрэл сэргээн засах эмчилгээний тасгийн орны тоог нэмэгдүүлснээр хүлээгдлийн дундаж хугацаа 27 хоног байсан бол 3 хоног болж буурсан.



Уг хэвтүүлэн эмчлэх ортой тасаг нь дүүргүүдийн эмнэлгүүдийн дундаа анхдагчаар байгуулагдаж байгаа бөгөөд үйлчлүүлэгчдийн сэтгэлд хүрсэн тусламж үйлчилгээний нэг болоод байгаа төдийгүй Уламжлалт,

сэргээн засах эмчилгээний эмч, мэргэжилтнүүд үйлчлүүлэгчидийн сэтгэлд хүрсэн, үр дүн сайтай шинэлэг тусламж үйлчилгээг нэвтрүүлсээр байна. Үүнд:

- “Мэдрэлийн зүү /Neuro-Acupuncture/ эмчилгээ
- “Хурууны үений хөдөлгөөн сайжруулах хавчаар”
- “Шагай ээтийлгэх сойлт”
- Тавцант сунгалт
- “Төөнүүр эмчилгээнүүдийг хэвшүүлээд байгаа бол



нэмж 2020 оны 2 сараас эхлэн Сэргээн засах эмчилгээний эмчлүүлэгчийн өрөөг шинээр бий болгож татлагын ортой болсон. Уг орны эмчилгээнд 5 сарын байдлаар нийт 76 эмчлүүлэгч хамрагдсан. Мөн барианы ороо 3-аар нэмэгдүүлж, таазны дусал тогтоогч хийсэн нь эмч, сувилагчийн ажлыг хөнгөвчилж, өвчтөнд таатай нөхцлийг бүрдүүлж өгч байна.

“Ахуй засал” өрөө: ЭМТ-ийн УСЗЭ-ний тасагт ахуй заслын өрөөгүй, ХБИргэд болон хүүхдүүдийн өдөр тутмын үйл ажиллагаа алдагдсан тохиолдол олон байдаг. Саа, саажилттай үйлчлүүлэгчдийн гар хөл үе мөчдын хөдөлгөөнийг сайжруулах тухтай таатай орчинг бүрдүүлж тухайн үйлчлүүлэгчид тохирсон хэрэгсэл дээр ажиллаж өдөр тутмын үйл ажиллагаа сэргээх зорилгоор **“Ахуй засал” өрөөг** шинээр тохижуулж нээсэн. “Хүүхдийн Ахуй засалын өрөө” нээж ажиллууснаар 2020 онд 0-5 насны 12 хүүхэд хөдөлгөөний хоцрогдол, тархины саажилт, аутизм, оюуны хомсдол, түнхий төрөлхийн мултрал, буруу алхалт зэрэг оноштой нийт давхардсан тоогоор 67 /15/ хүүхдэд тусламж үзүүлсэн.



“Хөдөлгөөн засал кабинет”: Тулгуур эрхтэний хөдөлгөөн хязгаарлагдсан, цус харвалтын дараах үлдэц саа саажилт, бэртэл гэмтэлтэй үйлчлүүлэгчдийн гар хөл үе мөчдын хөдөлгөөний далайцыг нэмэгдүүлэх үүднээс тухайн үйлчлүүлэгчид тохирсон хэрэгсэл дээр ажиллаж өдөр дутмын идэвхитэй үйл ажиллагаа сэргээх зорилгоор **“Хөдөлгөөн засал кабинет”**-ыг нээж ажилд оруулсан.



Хүүхдүүдэд хийгдсэн хөдөлгөөн болон хөдөлмөр засал эмчилгээ: толгой даалгах , эргэж хөрвөөх , булчингийн хүчний дасгал , булчингийн далайцын дасгал, булчингийн сунгалтын дасгал, зөв суулгах дасгал , мөлхүүлэх дасгал , зогсоох дасгал , багажийн тусламжтай суулгах, зогсоох дасгалууд , танин мэдэхүйн чадварыг сайжруулах дасгал хийгдсэн . **Үүний үр дүнд хүүхдүүд:** толгойгоо даан тогтвортой сууж, эргэж хөрвөөж чаддаг болсон, 4 хөллөж зөв мөлхөх, өөрөө сууж , босож , юм түшиж алхадаг болсон, хүний тусламжгүй алхаж чаддаг болж өдөр тутмын үйл ажиллагаа сайжирч , амьдралын чанар дээшилсэн.

Хөдөлгөөн заслын өрөөний тоног төхөөрөмжинд тулгуур эрхтэний хөдөлгөөн хязгаарлагдсан, цус харвалтын дараах үлдэц саа саажилт, бэртэл гэмтэлтэй үйлчлүүлэгчдийн гар хөл үе мөчдын хөдөлгөөний далайц алдагдсан давхардсан тоогоор 418 хүнд тусламж үйлчилгээ үзүүлснээс 295 хүн буюу 70% нь булчингийн хүчний дасгал, далайцын дасгал, босож суух алхах дасгалуудыг тус бүр хийсэнээр эмчилгээний дараа үйлчлүүлэгч туслах хэрэгсэлийн болон хүний тусламжтай амьдарлын чанар дээшилсэн.

Б. Төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний дэвшил:

Нүдний нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ: Тайлант хугацаанд 1376 хүний хараа шалгаж, ойр болон холын харааны шилийг 389 хүнд тааруулж, харааг хамгаалсан. Болорын хагалгаа 16, хялар засуулах хагалгаа 1, зовхи засуулах хагалгаа 2, нүдний өөхөн эдийн хавдар авахуулах хагалгаа 1, нүдний алим авахуулах хагалгаа 1 тус тус хийгдсэн.

Чих хамар хоолойн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ: Хүүхэд залуучуудын дунд элбэг тохиолддог гүйлсэн булчирхайн архаг үрэвслийг төгс эмчлэх зорилгоор гүйлсэн булчирхай авах мэс заслыг 2 хүнд орон нутагтаа хийсэн. УНТЭ-ийн ЧХХКСудлалд 19 хүнийг илгээж, гүйлсэн булчирхай авах хагалгаа 12, чихний хэнгэрэг нөхөх хагалгаанд 1, хамрын таславч мөгөөрсийг тэгшлэх хагалгаанд 6 хүнийг тус тус хамруулсан. АССР шинжилгээнд 42 хүнийг хамруулж, сонсголын аппарат 5 хүнд олгосон.

LEEP эмчилгээ: Эмэгтэйчүүдийн эсийн шинжилгээ-101, эдийн шинжилгээ-51, өсгөврийн шинжилгээ 32, үтрээний наац 1120 авсан. Шинжилгээ өөрчлөлттэй гарсан эмэгтэйчүүдийг эмчилгээнд харуулан, LEEP эмчилгээг 2 тохиолдолд хийсэн. Умайн хүзүүний хавдар 1, умайн хүзүүний хавдрын урьдал 5 тохиолдлыг илрүүлсэн.

Нүүр амны эрүүл ахуйчийг орон тоогоор ажлуулан амны хөндийн эрүүл ахуй, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлд шүдний үзлэг, эмчилгээний кабинетын эмч, сувилагч нартай хамтран ажиллаж байна. Тайлант хугацаанд бага насны хүүхдийн амны хөндийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хар түрхлэг 30, ховил хамгаалагч түрхлэг 4, фторт лак 127 хүүхдүүдэд тус тус хийгдсэн. Шүдний чулуу цэвэрлэх 198, шүдний өнгөлгөө 8, шүдний өнгөр тодорхойлох үйлчилгээг 8 хүүхдэд тус тус үзүүлсэн.

Сайн туршлага 2019” шинэ бүтээлийн өдөрлөгт танилцуулагдсан Хонхор тосгоны ӨЭМТ-ийн хүү, охины шүдийг эрүүлжүүлсэн байдлыг хянах картыг хэрэглэх туршлагыг нутагшуулж ГГЦС-ийн 4 ангийн хүүхдүүдэд хөтөлж судалгааны ажилд хийж хэлэлцүүлсэн.



В. Оношлогоо, шинжилгээний чиглэлээр

Дижитал рентген аппаратаар нийт 4087 хүнд, шүдний рентген зураг 696, Зөөврийн рентген DM-100MR аппаратаар 75, CARM хагалгааны үеийн зураг авалт 17 удаа, тодосгогч бодистой зураг авалт 4 удаа тус тус хийж үйлчилгээ үзүүлээд байна.

Сүүлийн үеийн Дижитал рентген аппараттай болсноор:

- Хамрын хугарал
- Нурууны хугарал болон бусад өөрчлөлтүүд
- Гавлын суурь ясны хугарал
- Жижиг шивнүүр ясны хугарал /хөл сарвуу г.м/
- Уушигны хавдар



оношлогоо хийх зорилгоор нийт 4 хүнд хийгээд байна. Дүүрэгтээ анх удаа гитеросалипингографийн шинжилгээг үргүйдэлтэй эмэгтэйчүүдэд оношлогооны зорилгоор умайн хөндий рүү тодосгогч бодистойгоор рентген зураг авалтыг амжилттай хийсэн.

➤ 1 нас хүртэл оношлогдоогүй явсан хүүхдийн өрцны ивэрхий зэрэг ховор, онцлог тохиолдлуудыг оношлож байна.

Тодосгогч бодистой рентген шинжилгээг:

- эмэгтэйчүүдэд үрийн хоолойн битүүрэл шалгах
 - хүүхдэд ивэрхий болон гэдэсний түгжрэл шалгах
- улаан хоолойн нарийсал ба хавдарын ялган




Рентген шинжилгээнд орж буй иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор иж бүрэн хамгаалах хувцасаар хангагдсан.




Ходоодны дурангийн оношлогоо:

Ходоодны дурангийн оношлогоог ЭМТөвд 111, дээд шатлалын эмнэлэгт 69 хүнд хийсэн ба ходоодны шарх 8, ходоодны ургацаг 3 илэрсэн. Ходоодны шархтай хүмүүсийг эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх болон амбулаториор эмчилгээ хийж, хяналтанд аваад байна. Улаан хоолойн судасны өргөсөл 6 хүнд оношилж, дээд шатлалын эмнэлэгт илгээж 4 хүнийг судас боох эмчилгээнд хамруулсан.



Монгол-Швейцарийн хамтарсан хүүхдийн төсөл (SMOPP)-өөс “Нярайн түнхний дутуу хөгжлийн хэт авиан скрининг” оношилгоог 2015 оноос хойш хийж байгаа бөгөөд 2020 онд эхний 5 сарын байдлаар нийт 232 нярайг хамруулж, хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлж чаджээ. Оношлогоонд хамрагдсан 232 нярайн /90%/ нь А, /8,7%/ нь В, /1,1%/ нь С, /0,18%/ нь D үнэлгээтэй байсныг хяналтанд авч, эмчилгээнд хамруулсан.

Зайн оношлогоо нэвтэрлээ: НҮБ –ийн хүн амын сангийн “Эх нярайн зайн оношилгооны төсөл”-ийн хүрээнд төрөх тасагт зайн оношилгооны өрөөг 2019 оны 7сард нээснээр хүнд өвчтөнд цаг алдалгүй лавлагаа шатлалын эмнэлэг /ЭХЭМҮТ/-тэй шууд харилцаж оношилгоо эмчилгээнд зөвлөгөө авах боломж бүрдсний дагуу тайлант хугацаанд эх барихын ноцтой хүндрэлийн 2 тохиолдол, нярайн ноцтой хүндрэлийн 1 тохиолдол нийт 3 тохиолдолд зөвөлгөө авч, 2 тохиолдодыг зөвөлгөөний дагуу эмчлэн хүндрэлээс гаргаж, 1 тохиолдодыг зөвлөмжийн дагуу тээвэрлэн лавлагаа шатлалын эмнэлэгт хүргэж өгсөн.



Лабораторийн магадлан итгэмжлэлд орох бэлтгэлийг ханган ажилаж байна. Үүний хүрээнд:

- Тоног төхөөрөмжүүдийг шинэчлэж, орчин үеийн шаардлагад нийцүүлэх
- Бичиг, баримт стандартуудыг шинэчлэн баталж, мөрдөх
- Эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулах ажлуудыг төлөвлөгөөний дагуу шат дараатай хийж байна.

Чанар ба чадавхид тавих шаардлага MNS ISO 15189:2015 стандартыг шаардлагыг хангаж ажиллах чанарын гарыг авлага хийх ажлын явц 80%, бусад бэлтгэл ажил 70%. Нийт бичиг баримтын шинэчлэл хийж ЭМС 650 тоот тушаалын дагуу АШМ-18, Бүртгэлийн маягт-32, чанарын бүртгэл-5 нийт 55маягт бүртгэлийн хуудас 100% шинэчилж дууссан.

Оношлогоо, шинжилгээний чанарыг сайжруулах зорилгоор сүүлийн үеийн оношлогоо шинжилгээний гематологийн болон **Insight U500 шээсний стрип уншигч** аппаратыг түрээсийн гэрээгээр Баянгол мед ХХК-аас шинээр авч суурилуулан ажиллуулж байна. Уг шинжилгээний аппаратууд нь:

- ✓ E-health программд хариуг илгээж, эмч нарт дамжуулах боломжтой
- ✓ Цусны эсийн бүтцийг графикаар гаргах
- ✓ Нугасны ус тоолох
- ✓ Цусны залуу эс тоолох
- ✓ Өндөгний цусыг шингэлж унших зэрэг давуу талуудтай. Тайлант хугацаанд клиник лаборатори 133793 шинжилгээ хийж үйлчилсэн.




Амьсгалаар хеликобактерийг оношлох шинжилгээний аргыг нэвтрүүлэн хийж байна. Уг арга нь орчин үеийн дэвшилтэт технологи бөгөөд нийт 11 үйлчлүүлэгч хамрагдсан ба оношлогооны чадавхи өндөр тул эмчилгээний үр дүнг хянахад ач холбогдолтой байна.



Нян судлалын лаборатори нь 2019 онд Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар ЭМСХ-5 төслийн хүрээнд иж бүрэн засвар тохижилт, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэний үр днд vitek® 2 compact нь 100

гаруй бактери, мөөгөнцрийн ялган дүйж, 50 гаруй антибиотик мэдрэг чанарыг тодорхойлдог боллоо. Энэхүү төсөл хэрэгжсэнээр тус эмнэлгийн нян судлалын лабораторийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжрахаас гадна эмнэлгийн тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт хяналт сайжирч, эрүүл ахуй, халдварын сэргийлэлтийн үйл ажиллагаа сайжирч орчин үеийн дэвшилтэт, шинэ технологи бүхий тоног төхөөрөмжүүдээр хангагдсан, эмч мэргэжилтэнд хардварын сэргийлэлт, хяналтын талаархи шинэ мэдлэг олгох, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, улмаар хуучин мөрдөж хэвшсэн уламжлалт арга барилыг өөрчилөн шинэчлэх, эмнэлгийн тусламж үзүүлэх үйл ажиллагааныхаа олон сургалтуудыг зохион байгуулснаар салбарын эмч мэргэжилтнүүдэд томоохон оюуны хөрөнгө оруулалт хийсэн ач холбогдолтой.



Vact-alert аппараттай болсноор цусны ариун чанарын шинжилгээнд агаартай, агааргүйтэн бактери илрүүлж байна.

Төсөл хэрэгжихээс өмнө нян судлалын шинжилгээнд нянгуудыг омогоор ялган ангилдаг байсан бол төслийн хүрээнд vitek® 2 compact аппараттай болсноор нянгийн ялган дүйлтийг агааргүйтэн бактер, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын үүсгэгч, олон эмэнд дасалтай бактериудыг зүйлийн түвшинд ялган дүйж байна. Тайлант хугацаанд нян судлалын лаборатори 14760 нян судлалын шинжилгээ хийж үйлчилсэн.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 оны 3 сард 29.8 сая төгрөгийн өртөг бүхий **плазмын автоклаваар** хангагдсны үр дүнд:

- Эмэгтэйчүүдийн зөвөлгөө өгөх кабинетийн гуурс
- Дурангийн мэс заслын туслах материал, хэрэгсэл
- Ходоодны дурангийн хэрэгсэл
- Хүлээн авах, хүүхэд, эрчимтийн тасагт хэрэглэгдэж буй амбуны болон бусад хуванцар хошуу, гуурс
- Чих хамар хоолойн кабинетийн туслах материал зэрэг 860 ширхэг багаж ариутгасан байна.

Ариутгалын үйл ажиллагаанд эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер болон халдвар судлагч эмч тогтмол хяналт тавин, химийн хяналтын аргаар хянаж, сард 1 удаа “Bowie Disk” тест ашиглан хяналт тавин ажиллаж байна.

3.3 Эрүүл мэндийн статистик үзүүлэлт 2020 оны эхний 5 сарын байдлаар:

- 2020 оны эхний 5 сарын байдлаар нийт үзлэг 100931 болж 73.4 хувь нь дүүргийн эрүүл мэндийн төвд, 26.6 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хийгдсэн байна. Үзлэгийн бүтцийн хувьд урьдчилан сэргийлэх үзлэг 39.36

хувь, өвчний учир амбулаторийн үзлэг 46 хувь, идэвхтэй хяналтын үзлэг 4.5 хувь, гэрийн идэвхтэй хяналтын үзлэг 9.6 хувь, гэрийн дуудлага 0.4 хувийг эзэлж байна.

- Стационарын тасагт 3560 өвчтөн хэвтэн эмчлүүлж нийт 24227 ор хоног ашигласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эмчлүүлсэн өвчтөн 31-ээр буурч, ор хоног 510-р буурсан байна. Дундаж ор хоног 6.82 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.08-р буурсан, орны эргэлт 16.60 болж 0.14-өөр буурсан байна. Орны фонд ашиглалт 113.21 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.38-аар буурсан байна.

№	Үзүүлэлтүүд	Нэгж	2019.05	2020.05	Зөрүү
1	Хэвтсэн өвчтөн	бодит тоо	3600	3560	-40
2	Гарсан өвчтөн	бодит тоо	3552	3531	-21
3	Эмчлүүлсэн өвчтөн	бодит тоо	3583	3552	-31
4	Ашигласан ор хоног	бодит тоо	24737	24227	-510
5	Орны фонд ашиглалт	бодит тоо	115.59	113.21	-2.38
6	Орны фонд ашиглалтын хувь	бодит тоо	84.07	82.33	-1.73
7	Дундаж ор хоног	бодит тоо	6.90	6.82	-0.08
8	Орны эргэлт	бодит тоо	16.74	16.60	-0.14

- 2020 оны эхний 5 сарын байдлаар 263 эх төрсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 төрлөг буюу 1.1 хувиар өссөн байна. Нийт төрөлтийн 21.6 хувь нь кесаров хагалгаагаар төрсөн нь өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар буурсан байна. Амьгүй төрөлтийн 2 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.
- Жирэмсний хяналтанд шинээр авсан эмэгтэйчүүдийн тоо 276, үүнээс эхний 3 сартайд хяналтанд орсон 235 (85.14 хувь) байна. Жирэмсний хяналтанд авсан эмэгтэйчүүдийн 9.4 хувь нь үр хөндүүлсэн байна.
- Нас баралтын нийт 51 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 тохиолдол буюу 1.9 хувиар буурсан байна. Эмнэлгийн нас баралтын 13 тохиолдол бүртгэгдсэн нь нийт нас баралтын 25.4 хувийг эзэлж байна. Үүнээс хоног болоогүй нас баралт 7 тохиолдол буюу эмнэлгийн нас баралтын 53.8 хувийг эзэлж өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар буурсан байна. Нийт нас баралтын 15 тохиолдол буюу 29.4% нь хорт хавдрын, 6 тохиолдол буюу 11.7% нь гадны шалтгаант нас баралт байна.
- 2020 оны эхний 4 сарын байдлаар нялхсын эндэгдэл өмнөх оны мөн үетэй /НЭМГ-ын эргэн мэдээлэхээс/ ижил түвшинд, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 1 тохиолдол бүртгэгдсэн байна.

№	Үзүүлэлтүүд	нэгж	2019.05	2020.05	Зөрүү
1	Бүх нас баралт	бодит тоо	52	51	-1
2	Эмнэлгийн нас баралт	бодит тоо	14	13	-1
3	Хоног болоогүй нас баралт	бодит тоо	8	7	-1
		хувь	57.1%	53.8%	-3.3%
4	Нялхсын эндэгдэл	бодит тоо	2	2	0

		1000 амьд төрөлтөд	10.4	10.3	-0.1
5	Перинаталь эндэгдэл	Бодит тоо	6	2	-4

Нас баралтын тэргүүлэх 3 шалтгаан:

№	Үзүүлэлт	Нэгж	2019.05	2020.05
1	Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	Бодит	52/19	51/18
		Хувь	36.5	35.3
2	Хавдар	НБ/Бодит тоо	52/10	51/15
		Хувь	24.4	29.4
3	Осол гэмтэл, гадны шалтгаан	Бодит тоо	52/7	51/6
		Хувь	13.5	11.7

- Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хувьд:
 - артерийн гипертензи өвчний эрт илрүүлэгт 18609 хүн хамрагдахаас 5133 хүн буюу 27.6%
 - чихрийн шижин өвчний эрт илрүүлэгт 18609 хүн хамрагдахаас 5101 хүн буюу 27.4%
 - умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт 1894 хүн хамрагдахаас 1013 хүн буюу 53.5%
 - хөхний хавдрын эрт илрүүлэгт 7565 хүн хамрагдахаас 2550 хүн буюу 33.5%
 - Элэгний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 763 хүн хамрагдахаас 268 хүн буюу 35.1 хувь нь тус тус хамрагдаад байна.
- Халдварт өвчний нийт 132 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21 тохиолдол буюу 13.7 хувиар буурч 10000 хүн амд 45.53 болсон байна. Үүнд дотроо бэлгийн замын халдварт өвчин 82 тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 6 тохиолдол буюу 10000 хүн амд 1.87 тохиолдлоор өссөн бол цочмог халдварт өвчний 44 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 23 тохиолдол буюу 10000 хүн амд 7.81-р буурсан байна. Мөн шинэ сүрьеэгийн 6 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3 тохиолдол буюу 33.3 хувиар буурсан байна.

№	Үзүүлэлтүүд	нэгж	2019.05	2020.05	Зөрүү
1	Бэлгийн замын халдварт өвчин	Бодит тоо	76	82	6
		10000 хүн амд	26.07	28.28	1.87
2	Цочмог халдварт өвчин	Бодит тоо	67	44	-23
		10000 хүн амд	22.98	15.18	-7.81
3	Сүрьеэ өвчин	Бодит тоо	9	6	-3
		10000 хүн амд	3.09	2.07	-1.02
4	Нийт халдварт өвчин	Бодит тоо	152	132	-20
		10000 хүн амд	52.14	45.53	-6.61

Статистик үзүүлэлтийг сайжруулах чиглэлээр: Байгууллагын хэмжээнд 51 төрлийн үндсэн үзүүлэлтийг сар, улирлаар дүгнэж ажилладаг бөгөөд энэ жилийн хувьд хоног болоогүй нас баралтыг бууруулах, перинаталь эндэгдэлийг бууруулах, 1-5 нас хүртэлх хүүхдийн эндэгдлийг бууруулах, гэрийн төрөлт болон

хяналтгүй төрөлтийг бууруулах, үндсэн оношийн зөрүү бууруулах, мэс заслын хүндрэл гаргахгүй ажиллах, ӨЭМТ-үүдийн гэрийн идэвхтэй эргэлтийн хувийг өсгөх, эрт илрүүлгийн үзлэгийн хувийг нэмэгдүүлэх зэрэг үзүүлэлтүүд дээр илүү анхаарч ажиллаж байна.

3.4 Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор сууршилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв нь 230 ор, 17 тасаг нэгжтэйгээр дүүргийн болон Төв, Хэнтий аймгийн ойролцоох 8 сумдын хүн амд нэгдсэн эмнэлгийн бүтэц, орон тооны стандарт MNS5095:2017-ын дагуу тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Хүний нөөцийн хувьд нийт 319 ажилтантай. Үүнд:

- Их эмч 71
- Эм зүйч 2
- Халдвар судлагч их эмч 2
- Нийгмийн эрүүл мэндийн ажилтан - 2
- Биоанагаах судлаач 3
- Сувилагч, эмнэлгийн тусгай дунд мэргэжилтэн 140 /сувилагч 102, тусгай мэргэжилтэн 38/
- Туслах сувилагч 7
- Бусад дээд мэргэжилтэн 14
- Үйлчлэгч 35, бусад туслах үйлчилгээний ажилтан 34 ажиллаж байна.

Одоогийн байдлаар:

- 10000 хүн амд ноогдох их эмчийн тоо 35
- 10000 хүн амд ноогдох сувилагч, эмнэлгийн тусгай дунд мэргэжилтний тоо 48
- Нэг эмчид ноогдох сувилагчийн тоо 1.4 байна.

Эмч, Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэргийн хувьд:

- Тэргүүлэх зэрэгтэй эмч 5
- Ахлах зэрэгтэй эмч 13
- Тэргүүлэх зэрэгтэй сувилагч дунд мэргэжилтэн 11
- Ахлах зэрэгтэй дунд мэргэжилтэн 57 болж эмч нарын 27%, дунд мэргэжилтнүүдийн 48% нь мэргэжлийн зэрэг хамгаалж мэдлэг мэргэжил ур чадвараа дээшлүүлсэн.

Боловсролын зэрэг цолны хувьд:

- Клиникийн профессор цолтой эмч 8
- Магистр эмч 17, сувилагч 2, нийт 19 эмнэлгийн мэргэжилтэн
- Бакалавр зэрэгтэй сувилагч -26 ажиллаж байна.

Эмч нарын 89%, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн 52.4% нарийн мэргэжил эзэмшсэн. Нарийн мэргэжил шаардагдах ажил, албан тушаалын хангалт 90% байна.

Мэргэшүүлэх болон чадваржуулах сургалтанд хамруулж, мэдлэг мэргэжил, боловсролыг дээшлүүлж буй байдал:

Тайлант хугацаанд байгууллагад хэрэгцээ шаардлагатай, дутагдалтай байсан чиглэлээр эмч, сувилагч нарын сар бүрийн үндсэн цалинг олгон сургалтаа төгсөөд тус эрүүл мэндийн төвд 5-10 жил тогтвор суурьшилтай ажиллах хатуу гэрээ байгуулсан сургалтанд хамруулаад байна. Үүнд:

Мөн үндсэн мэргэжил олгох сургалтанд:

- Гэмтэл согог засал судлал-1
- Мэдээгүйжүүлэг судлал -1
- Нүд судлал -2
- Хүүхэд судлал- 3
- Дүрс оношлогоо судлал -1
- Сэтгэц судлал-1
- Чих хамар хоолой судлал -2
- Дотор судлал-3
- Хавдар судлал-1
- Эх барих эмэгтэйчүүд судлал -1
- Яаралтай түргэн тусламж судлал-1
- Сүрьеэ судлал-1 зэрэг чиглэлүүдээр нийт 18 их эмчийг

Төрийн сангийн тэтгэлэгээр сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд төгсөлтийн дараахь нарийн мэргэжил олгох сургалтанд:

- Мэдээгүйжүүлэг судлал-1
- Дурангийн хэт авиа оношлогоо-1
- Ерөнхий мэс засал судлал-1
- Гэмтлийн мэс засал судлал-1
- Бариа заслын сувилахуй-1
- Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй судлал-1 нийт 6 сувилагч, тусгай мэргэжилтэн, нийт 24 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэнг сургалтанд хамруулсан нь Эрүүл мэндийн төвийн эмчилгээ үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэхэд чухал нөлөө бүхий ажил боллоо.

Манай байгууллага нь 2020 оныг “ӨӨРЧЛӨЛТИЙГ ӨӨРӨӨСӨӨ ЭХЭЛЦГЭЭЭ” уриан дор ёс зүй, харилцаа хандлагаа дээшлүүлэх зорилтыг тавин, оны эхнээс тасаг нэгжүүдийн эрхлэгч нарт ил захидал илгээсэн.

Үүний хүрээнд 2020.01.24-нд “ЭЕРЭГ ХАНДЛАГА” сургалтыг Багануур дүүргийн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд 228 хүнд Эерэг хандлага сургалтыг гаднаас эрдэмтэн багш нарыг урьж ирүүлэн хийсэн. Уг сургалтанд:

- ЭМТ-ийн 17 тасаг нэгжийн 213 ажилчид
- Цэргийн 0252-р анги, ӨЭМТөв, сургууль, цэцэрлэгийн 15 эмч мэргэжилтэнүүд тус тус хамрагдсан.



Судалгаа, шинжилгээ:

Багануур дүүргийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу "ШИНЖЛЭХ УХААН-БҮТЭЭЛ-ИННОВАЦИ" сэдвийн дор залуу эмэгтэй судлаачдын эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан дүүрэгт 4 дахь жилдээ зохион байгуулагдсан. Уг илтгэлийн уралдаанд нийт 13 илтгэл хэлэлцүүлэгдсний 5 нь манай эмэгтэй эмч, сувилагч, мэргэжилтэн судлаачдын илтгэл оролцсон бөгөөд

3-р байранд Нийгмийн эрүүл мэндийн ажилтан Д.Бүдханд

4-р байранд Мэдрэлийн их эмч Ц.Байгалмаа нар шалгарч

МЭИТМЭ-ийн холбооны тэргүүний нэрэмжит шагналаар УАУ-ны их эмч Ц.Хулан тус тус шагнагдсан.

2020 оны 06 сарын 03-ны өдөр "Бүх нийтийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг-2020" онол практикийн хурлын 1-р шатны хэлэлцүүлгийг байгууллагын хэмжээнд зохион байгуулж ЭМТ-ийн нийт 10 тасаг нэгжийн 30 сувилагч, тусгай мэргэжилтэнгүүд оролцоод байна.

2-р шатны хэлэлцүүлгийг 6 сарын 17-нд АШУҮИС-ийн эрдэмтэн багш нартай хамтран хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Албан хаагч нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэхээр хэрэгжүүлсэн ажлууд:

Эмч, ажилтнуудыг эрсдлээс хамгаалах зорилгоор 2020 онд Практикал даатгалтай ХЧТА, Гэнэтийн осол, хариуцлагын даатгалын хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. нийт 45 хүнийг даатгалд хамруулаад байна.

Томуу, томуу төст өвчний өвчлөл болон БНХАУ-ын Үхань хотод гарсан шинэ коронавирусын халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийнхээ дархлааг дэмжих зорилгоор 2020 оны 01 сарын 22-ны өдрөөс 04 сарын 01-ны өдрийг хүртэл ажлын байранд нь өдөр бүр халуун аарц, чацаргана, аньсаар үйлчилж, витаминжуулах ажлыг зохион байгуулж ажилласан. Үүнд нийт 6,599,946 төгрөг зарцуулагдсан.



Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журмын дагуу 2020 оны нэгдүгээр улирлын урамшууллыг 0-40% тооцож нийт ажилтнууддаа олгосон бөгөөд 2-р улирлын урамшууллаас эхлэн 60 хүртэл хувиар олгохоор шийдвэрлэн журамаа шинэчлэн ажиллаж байна.

Байгууллагын дотоод журамд заасны дагуу ар гэрийн гачигдал гарсан 9 эмч, сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтэнд тус бүр 100000 төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон.

ЭМС-н А/69 тоот тушаалын хэрэгжилтийг ханган тасаг нэгжийн эрхлэгч, ахлах сувилагч нарт хариуцлагын нэмэгдлийг үндсэн цалингийн 10%-р тооцон олгож байна

Албан хаагчдын шагнагдсан байдал: Тайлант хугацаанд нийт 24 ажилтан шагнагдсанаас:

- ЭМЯ-ны “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэгээр- 2
- ЭМЯ-ны “Жуух бичиг”-ээр – 3
- НЭМГ-ын “Тэргүүний ажилтан” цол тэмдэгээр – 1
- НЭМГ-ын “Өргөмжлөл”-өөр – 1
- Дүүргийн ИТХ-ын “Өргөмжлөл”-өөр – 1



- Дүүргийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр – 2
- Дүүргийн Засаг даргын “Баярын бичиг”-ээр – 1
- Монголын сувилагчидийн нийгэмлэгийн шагналаар 10
- Дүүргийн ЗД-ын Алтан чагнуур шагналаар 2 ажилтан албан хаагч тус тус шагнагдаад байна.

Албан хаагчдын эрүүлжилт: Нийт 65 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тархвар судлалын заалтаар дархлаажуулалтанд хамруулан 13 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнг В вирус илрүүлэх шинжилгээнд /ELISA/ хамруулж, В вирусын эсрэг дархлаажуулалтанд хамруулсан. Төрөх нярайн тасгийн 17 эх баригч, сувилагч нар ЭМС-ын 537 тоот тушаалын дагуу эрүүл зүйн шинжилгээнд хамрагдсан.

Багануур сувилал ХК-тай зөвшилцөн 72%-н хөнгөлттэй хоногийн 10 мянган төгрөгийн төлбөртэйгээр ЭМТ-н 68 эмч эмнэлгийн мэргэжилтэнүүдийг эмчилгээ сувилгаанд хамруулсан.

3.5 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл

Эхний 5 сарын байдлаар чанарын албанд эмнэлгийн эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой талархал, санал, хүсэлт, өргөдөл, гомдол 57 ирснээс биелэлт 100% байна

Саналын тоо – 0

Шийдвэрлэлтийн хувь – 100%

Гомдлын нийт тоо – 7

Шийдвэрлэлтийн хувь – 100%

Хүсэлтийн тоо – 12

Шийдвэрлэлтийн хувь – 100%

Талархалын тоо – 38

Хувь – 100%

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:
“БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”

Багануур Эрүүл мэндийн төв – Facebook нээлттэй групп, Багануур Эрүүл мэндийн төв – Facebook page хуудас болон www.bnemn.ub.gov.mn сайт, байгууллагын мэдээллийн самбарт Эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагааны стратеги зорилт, зорилго түүний үйл ажиллагааны биелэлт, тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны тайланг тухай бүр шинэчлэн байршуулж байна.



Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн болон өргөдөл, гомдол хүлээж авах 15 удирдах ажилчдын мэдээллийг Багануур Эрүүл мэндийн төв – Facebook нээлттэй групп, Багануур Эрүүл мэндийн төв – Facebook page хуудас болон www.bnemn.ub.gov.mn сайт, байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.

Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудсууд болон мэдээллийн самбар байгууллагын угтах хэсгийн LED дэлгэцэнд тогтмол байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна.

Байгууллагын төсвийн төлөвлөгөө, мэдээ, тайлан, гүйлгээ, хөрөнгө гаргахтай холбоотойгоор гарсан тушаал шийдвэр, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгүүд, хүний нөөцийн мэдээллийг шилэн дансны мэдээлэл тавих хугацааны дагуу байгууллагын вэб хуудсанд сар бүр байршуулж байна. Тайлант хугацаанд төсөв, орлого зарлагын 12 мэдээг байршуулсан.

Байгууллагын вэб сайтын ил тод байдал цэсэнд статистикийн мэдээ, мэдээллийг сар бүр шинэчлэн тавихаас гадна ханын самбар байршуулан иргэдэд мэдээлэл хүргэж байна.



Вэб сайтын мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэн баяжуулж вэб сайтад тавигдах MNS 6285:2011 стандартыг мөрдлөг болгон байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг <http://www.bnemn.ub.gov.mn/> цахим хуудас, “Багануур

дүүргийн эрүүл мэндийн төв” facebook хуудсаар ил тод, нээлттэй, шуурхай хүргэн ажиллаж байна.

Вэб сайтын мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэн баяжуулж вэб сайтад тавигдах MNS 6285:2011 стандартыг мөрдлөг болгон байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг <http://www.bnemn.ub.gov.mn/> цахим хуудас, “Багануур дүүргийн эрүүл мэндийн төв” facebook хуудсаар ил тод, нээлттэй, шуурхай хүргэн ажиллаж вэб сайтанд 116 мэдээ, мэдээллийг оруулан, фэйсбүүк хуудсанд нийтлэлийнхээ линкийг хуулж нийтэд түгээж байна. Нийт вэб хуудсаар орж мэдээлэл авсан хандалтын тоо 25933 байна.

Дүүргийн орон нутгийн “Сүлжээ-3 телевиз, FM 104.5 радиогоор цаг үеийн мэдээ, мэдээлэл, сургалт, өдөрлөгийн үйл ажиллагаа, эрүүл мэндийн зөвлөгөөг 62 удаа хүргэн ажиллалаа.



ЭМТ-ийн 15 тасаг нэгжийн ахлах сувилагч, стационарын 9 тасгийн сувилахуйн пост, компьютераар хангагдан дотоод сүлжээнд холбогдон EHealth программд өвчний түүх нээх, нарийн мэргэжлийн кабинетад үзүүлэх үйлчлүүлэгчийн захиалга нэрийг оруулж товлот цаг авах зэрэг үйлчилгээг цахимаар хийж байна.

Байгууллагын төсвийн төлөвлөгөө, мэдээ, тайлан, гүйлгээ, хөрөнгө гаргахтай холбоотойгоор гарсан тушаал шийдвэр, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэгүүд, хүний нөөцийн мэдээллийг шилэн дансны мэдээлэл тавих хугацааны дагуу, шилэн данс болон байгууллагын вэб хуудсанд сар бүр байршуулж байна. Тайлант хугацаанд төсөв, орлого зарлагын 26 мэдээг байршуулсан.

Эмнэлэг хяналтын комиссын хурлыг 23 удаа хуралдуулж, 1646 хүний асуудлыг шийдвэрлэсэн. ХЧА-ыг шинээр 37 хүнд тогтоож, сунгалтыг 211 хүнд хийж, 25 хүнийг цуцалсан. ЭМСайдын 2012 оны 04сарын 20-ны 129 тоот тушаал “Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох журам”-ын дагуу үнэ төлбөргүй эмийг 155 хүнд олгосон. Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас 13А маягтаар 823 хүнийг дээд шатлалын эмнэлэгт илгээж үзлэг, оношлогоо, эмчилгээнд хамруулсан. Байнгын асаргаа шаардлагатай иргэнээр 62 хүнийг тодорхойлж, асран хамгаалагчийн сунгалтыг хийсэн. Өвчний учир ажлаас чөлөөлөх актыг 142 хүнд тодорхойлсон. Эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг 226 хүнд гаргасан.

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв нь дараах программ хангамжуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

№	Ашиглагдаж буй программ
1	E-health
2	Mn obstetrics
3	erp ulaanbaatar-Бичиг хэрэг хүний нөөц
4	erp ulaanbaatar-өргөдөл гомдол
5	Oculus санхүүгийн программ
6	Payroll санхүүгийн программ
7	Pharmacy эмийн сангийн программ
8	health.gov.mn - даатгалын мэдээ
9	health.gov.mn - элэг бүтэн
10	health.gov.mn - эмийн жор бичих
11	health.gov.mn - у/с үзлэг
12	h-info
13	Ewar 2.0 –Халдварт өвчнийг эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ
14	Screening.mn -Хавдрын эргэн дуудах тогтолцооны бүртгэлийн программ
15	Flu.mn – томуугийн харуулан тандалтын мэдээний бүртгэл
16	Cancer.mn – Хавдар өвчнийг бүртгэх, мэдээлэх, хянах
17	Ubhealth.mn – Архины хордлого, хүлээгдлийн мэдээ, төрөлтийн мэдээ
18	E-Health.gov.mn – Төрөлт, нас баралт, Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн тайлан мэдээ
19	ENEMUT.MN- төрсөн хүүхдийн мэдээ
20	cardiocenter.telemedicine.mn/ Зүрх судасны секторын тохиолдол бүртгэл, хяналт
21	XPLATFORM9.2_SetupEngine.cab Төрийн өмчийн харилцааны газрын “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем” – ийн хүрээнд хэрэгжиж буй програм
22	tubis.mn Сүрьеэгийн тохиолдол бүртгэх програм
23	66.181.170.27:8080/nud/ ЭХЭМҮТөвийн хүүхдийн нүдний өвчлөлийн тохиолдол бүртгэх
24	Тархины цахилгаан бичлэгийн програм
25	Хавдарын тохиолдол бүртгэх програм
26	Scope Pro V.2 Ходоодны дурангийн програм
27	vssm дархлаажуулалтын программ
28	hepsupdate.ontime.mn мэдээлэл тоног төхөөрөмж болон эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэх

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ:

Энэ оны 5 сарын байдлаар сэтгэл ханамжийн судалгааг нийт 4 удаа авч нийт 700 хүн хамруулсан. Үүнд:

1. Байгууллагын соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, удирдлага, зохион байгуулалт, тэгш байдал, ашиг сонирхолын талаар хэвтэн эмчлүүлэгчдийн тасгаас 150 үйлчлүүлэгч хамрагдсан. Дундаж хувь 84 гарсан.
2. Байгууллагын соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, удирдлага, зохион байгуулалт, тэгш байдал, ашиг сонирхолын талаар амбулаторийн тасгаар

үйлчлүүлж буй 150 иргэд, үйлчлүүлэгчид хамрагдсан. Дундаж хувь 83 гарсан.

3. Байгууллагын дэмжлэгт удирдлага, хүний нөөцийн хөгжих боломж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, байгууллагын соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, ажлын байрны аюулгүй байдал, дэмжлэгт орчны талаар эмч, ажилчдаас 250 ажилтан хамрагдсан. Дундаж хувь 80 гарсан.
4. Өрхийн эрүүл мэндийн төвийн эмнэлгийн соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, удирдлага, зохион байгуулалт, тэгш байдал, ашиг сонирхлын талаар 150 иргэд үйлчлүүлэгчид хамрагдсан.

Сар бүр сэтгэл ханамжийн судалгааг нэгтгэн дүгнэж, чанарын албаны даргад танилцуулан, чанарын албаны дарга бүх нийтийн ажилчдын болон, эмч, сувилагч нарын цуглаанд танилцуулж хэвшсэн. Тухайн тасаг, нэгжийн тасгийн эрхлэгч, ахлах сувилагч, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт дүгнэлт, төлөвлөгөөг тодорхой хугацаатайгаар өгч, төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн:

	Үйлчлүүлэгчийн эерэг сэтгэл ханамжийн хувь	Эмч, эмнэлгийн ажилчдын эерэг ханамжийн хувь
2019.5 сарын байдлаар	89%	74%
2020.5 сарын байдлаар	83%	80%

ТАВДУГААР БҮЛЭГ: “БУСАД МЭДЭЭЛЭЛ”

5.1 Байгууллагын харъяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай мэдээлэл

МУ-ын ЗГ-ын 2011 оны 311 тоот тогтоолын дагуу аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.

2020 онд Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн болон Чанарын алба, Халдвар хяналтын алба, Сувилахуйн албаны дэргэд орон тооны болон орон тооны бус дотоод хяналтын зөвлөлүүд ажиллаж байна. Хийсэн хяналтуудаас:

- Чанар, аюулгүй байдлын алба, Халдвар хяналтын алба, Сувилахуйн албатай хамтран ЭМТ-ийн тасаг нэгжүүдэд ЭМС-ийн 537 тоот тушаалын дагуу 6 удаа дотоодын хяналтыг зохион байгуулсан.
- Мэс заслын хагалгааны явцад халдвар хамгааллын дэглэм хэрхэн баримталж байгаа эсэхэд хяналт хийсэн /камерын бичлэгээр/. Хяналтаар илэрсэн зөрчилийг газар дээр нь болон хугацаатай үүрэг өгч арилгуулж ажилласан.
- Эрүүл мэндийн төвийн эмчилгээний хоол үйлдвэрлэл эрхэлж буй “Хархираа Уянга” ХХК-ийн үйл ажиллагаанд ЧАБАлбаны чанарын менежер Н.Мөнхзаяа, халдвар судлагч Г.Хишигсүрэн нар хамтран 2 удаа хяналт

үнэлгээг хийж илэрсэн зөрчлийг газар дээр нь болон хугацаатай үүрэг өгч арилгуулж ажилласан .

Халдварын сэргийлэлт хяналтын багийг 1 удаа хуралдуулж дотоодын хяналтаар илэрсэн зөрчил болон 2020 оны 05 сарын 14-ны өдрийн НМХГ-ын хяналт шалгалтаар илэрсэн зөрчилийг арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын тухай хэлэлцсэн.

ЭМТ-ийн тасаг нэгжүүдийн эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн байдалд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах зорилгоор агаар – 20, арчдас – 131 –ийг авч ЭМТ-ийн нян судлалын лабораторит шинжлүүлсэн. Мөн НМХГ-ын төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд тасаг нэгжүүдээс агаар-15, ариун материал-6, эрүүл зүйн арчдас-30-г авч Мэргэжлийн хяналтын хэлтсийн бичил амь судлалын лабораторит шинжлүүлэхэд 2 буюу төрөх өрөө, халдвартын тасгийн үйлчлүүлэгчдийн өрөөний агаар дахь бичил биетний ерөнхий тоо зөвшөөрөгдөх хэмжээнээс их гарч тухайн тасаг нэгжүүдэд холбогдох арга хэмжээг авсан.

ЭМС-ын 539 дүгээр тушаалын дагуу түгээмэл тохиолддог ЭТҮХХ-ыг илрүүлэх тандалтыг мэс ажилбарын дараах шархны халдварыг шинж тэмдгээр тандах хуудас, судасны гуурстай холбоотой халдварыг тандах хуудас, шээлгүүртэй үйлчлүүлэгчдийн дунд бөөр, шээсний замын халдварыг тандах хуудас, амьсгалын аппараттай үйлчлүүлэгчдийн дунд уушгины хатгалгааг тандах хуудсаар тогтмол хийж байна.2020 оны эхний 5 сарын байдлаар ЭТҮХХ –ын тохиолдол бүртгэгдээгүй.

Амбулаторийн тусламж үйлчилгээ, түүнд хөтлөгдөж буй анхан шатны маягтуудын байдалд дотоод хяналт үнэлгээг хийсэн.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар, өртөлт эрсдэлээс сэргийлэх хяналтын хуудсыг ЭМСайдын 537-р тушаалын дагуу тасгийн онцлогт тохируулан боловсруулж гаргасан. Нарийн мэргэжлийн кабинетуудад хяналтын хуудасны дагуу давхардсан тоогоор 304 удаа хяналт хийж, гарсан зөрчлийг дор нь арилгуулсан. Нарийн мэргэжлийн кабинетуудад оношлогоо эмчилгээний стандарт, түгээмэл үйлдлийн стандартын мөрдөлтөнд аудит хяналтыг хийсэн. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, халдвар хяналтын тогтолцоо, хог хаягдлын менежментүүдийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахын тулд дараах хяналтуудыг үе шаттайгаар хийж үнэлгээ дүгнэлт өгч, гарсан зөрчлийг богино хугацаанд арилгуулах зорилгоор ажиллаж байна. Нийт давхартсан тоогоор 169 зөрчил илэрснийг хугацаатай үүрэг өгч, зөрчлийг арилгуулсан.

- Халдвар хамгаалал 94,9%
- Хог хаягдал 92,8%,
- АШМ хөтлөлт 93,2%
- Ус саван ашиглан гар угаах 94%
- Тусламж үйлчилгээний бэлэн байдал 100%
- Тоног төхөөрөмжийн халдваргүйтэл 100%, Дундаж үнэлгээ **95,8%** байна.

Клиник биохимийн лабораторийн өдөр тутмын дотоод хяналт:

- Биохимид 2 түвшиний хяналтаар 19 үзүүлэлтээр 145 удаа,
- Гематологи 3 түвшиний хяналтаар 76 удаа,

- Шээсний ерөнхий шинжилгээ 2 түвшний хяналтаар 36 удаа,
- ELISA, TPNA, RPR цуврал шинжилгээ бүрт эерэг сөрөг хяналт өдөр бүр хийгддэг. Өдөр бүр дотоод хяналтуудыг баримтжуулан залруулах арга хэмжээ хийгддэг мөн сар бүрээр дотоод хяналтуудыг нэгтгэж дүгнэлт хийдэг.

Нян судлалын лабораторийн чанарын гадаад хяналт:

- ХӨСҮТөвд өсгөвөрийн гадаад хяналтын 1 удаа / 2 сорьцны төрөлд/ 93 % үнэлгээ.
- ХӨСҮТөвд Наацын шинжилгээний 6 сорьц 100% үнэлгээтэй.
-

Клиник лаборатори 2020 онд:

- биохими-2,
- гематологи-2,
- иммунологи-2,
- иммуногематологит 2 нийт 8 гадаад хяналтанд хамрагдах хуваарьтайгаас эхний хяналтанд 6-р сард орохоор хуваарь гарсан байгаа.

5.2 Санхүүжилт, хөрөнгө оруулалт болон байгууллагын тохижилт, үйлчилгээг сайжруулах чиглэлээр хийсэн ажил, үр дүнгийн талаар

2020 оны эхний 5 сарын байдлаар улсын төсвийн санхүүжилт 100 %, НДСангийн санхүүжилт 97 %, өөрийн орлогын төлөвлөгөө 97,3%-ийн гүйцэтгэлтэй байна.

№		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
1	Эрүүл мэндийн даатгалын сангаас	1 643 680,5	1 594 370,26	49 310,23
2	Улсын төсвөөс	1 545 300,0	1 545 300,0	0
3	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	39 523,5	38 456,98	-1 066,51
Нийт		3 228 504,0	3 178 127,25	50 376,74

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 97 %-ийн гүйцэтгэлтэй байгаа нь дараах үндэслэлтэй. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг дараа сард нь гүйцэтгэлээр нэхэмжилдэг тул тухайн сард 70-85% аар урьдчилгаа санхүүжилт ордог.
- Өөрийн орлогын санхүүжилт 97,3%-ийн гүйцэтгэлтэй байгаа нь түрээсийн орлого дутуу орсон.
- 2019 оны эцсээр 4 түрээслэгчийн 4 680,6 мянган төгрөгийн түрээсийн авлагатай байсан нь барагдаагүй.
- 2020 оны эхний 5 сарын байдлаар 4 түрээслэгчийн 10 322,9 мянган төгрөгийн түрээсийн, 49 310,23 мянган төгрөгийн ЭМДсангийн санхүүжилтийн авлагатай байна.

Эмийн зардалд 133933,5 хоолны зардалд 4 683,0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 4 545,1 мянган төгрөгийн, урсгал засварын зардалд 1 295,0 мянган төгрөгийн, Цалингийн зардалд 294 697,95 мянган төгрөгийн НДШимтгэлд 63 927,09 мянган төгрөгийн өглөгтэй байгаа нь төсөв хүрэлцэхгүй цалин нэмэгдсэн, ковид-19 дэгдэлттэй холбоотой илүү цагаар ажиллуулсан, 1-р сард үр дүнгийн урамшуулал олгосонтой холбоотой цалингийн зардал өссөн.

2019 оны төсвийн төсөлд тусгуулах урсгал болон их засварын судалгааг гаргаж, хүсэлтээ НЭМГ-ийн хөрөнгө оруулалт, НЗТГ-ын Хөрөнгө оруулалтын газарт тус тус хүргүүлээд байна.

ЭМТ-ийн өргөтгөл /төрөх тасаг/-ийн барилгыг улсын төсвийн 2,4 тэрбум төгрөгөөр барихаар төсөвт сууж барилгын зураг төсвийг “ЭМ ЭС ЭЛ” ХХК гүйцэтгэж төсвийн хуваарийн дагуу 2019 онд хийгдэх 1,4 тэрбум төгрөгний ажлын гүйцэтгэгчээр "Өгөөмөр баян дэнж" ХХК шалгарч 2019.10.29-ны өдрөөс ажлыг эхлүүлж 2020.05.30-ны байдлаар зоорийн давхараас 3 давхар хүртлэх карказ угсралтын ажил, зоорийн давхарын туслах хананы өрлөгийн ажил дуусаад, 1 давхарын болон техникийн өрөөний ханнаны угсралт, өрлөг, зоорийн давхарын агааржуулалтын системийн хоолойн угсралтын ажлууд хийгдэж байна. Гүйцэтгэл 65%-тай.



ЭМТ-ийн төв корпусны арын хэсэгт Нийслэлийн хөрөнгө оруулалт 1,5 тэрбум төгрөгөөр 5200 м/кв шинэ авто зам, 5400 м/кв сэргээн засварлах авто зам, 410 м/кв авто зогсоол, 16200 м/кв талбайд зүлэгжүүлэлт засвар, тохижилт, шинэчлэлийн ажлыг хийж байна.



Нийслэлийн 120 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар төв корпусын барилгын хойд талын гадна фасадны дулаалгын ажлыг хийж гүйцэтгэж дуусгасан бол энэ онд үлдсэн 3384м/квт талбайд гадна фасадны дулаалгын ажлыг Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийхээр төлөвлөсөн. Гүйцэтгэгчээр “Рашпай” ХХК шалгарч 2020.06.08-ны өдрөөс ажил эхлээд байна.



Төвийн цахилгаан тасадсан үед ажиллуулах цахилгаан үүсгүүрийг байрлуулан холбож, гадна байрыг барьж, ашиглалтанд оруулсан.



Тайлант хугацаанд эмнэлгийн нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх ажлын Хүчилтөрөгч өтгөрүүлэгч-2

- Тарианы автомат шахуурга-1
- Дуслын шахуурга-1
- Утлагын аппарат -2
- Амьсгалын аппарат-1
- Өвчтөний хяналтын монитор-2
- Зөөврийн рентген аппарат-1
- Зөөврийн ЭХО-1
- Микротом-1
- Шүдний бор машин-2-оор тус тус хангагдан эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглаж байна.

Улирлын томуу, томуу төст өвчиний дэгдэлт болон шинэ халдвар болох коронавирус дэлхий дахинд гарч эрүүл мэндийн байгууллага өндөржүүлсэн бэлэн байдалд шилжээд байгаа төдийгүй эмнэлгийн ачаалал нэмэгдэж хүчилтөрөгчийн хэрэгцээ эрс өссөн тул Багануур ХК нийгмийн хариуцлагынхаа хүрээнд эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай хүчилтөрөгчийг 2020.02.01-ны өдрөөс эхлэн одоог хүртэл хугацаанд үнэ төлбөргүй хангаж байна. Энэ нь манай байгууллагын хувьд 3,5 сая.төгрөгний эдийн засгийн хэмнэлтийг үүсгэж байгаа төдийгүй зах зээлийн ханшаар тооцвол Багануур ХК 10 сая орчим төгрөгний хүчилтөрөгчийг манай байгууллагад үнэ төлбөргүй нийлүүлээд байна.

Өмнө нь манай байгууллага нь хүчилтөрөгчөө Улаанбаатар хотоос тээвэрлэн эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэж байсан нь яаралтай тусламжийн үед хугацаа алдах эрсдэлийг дагуулж байсан.

Мөн хүчилтөрөгчийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд хүчилтөрөгчийн ханын шугамыг ЭЭХА, Халдварт, Хүүхэд, Нярайн тасгуудад суурьлуулаад байна.

ОЛОЛТ, АМЖИЛТУУДААС:

Шинэ технологи, оношлогоо эмчилгээний удирдамж, стандарт нэвтрүүлсэн байдал:

1. Иргэн П.Ө 64 настай, эмэгтэй, баруун дунд чөмөгний хүзүү дайрсан хугарал,

- Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэс заслын тасагт анх удаа түнхний үе солих мэс заслыг амжилттай хийсэн.
- Иргэн Т.Э 53 настай, эмэгтэй, цөсний ерөнхий сувгийн гаж хөгжил, цөсний хүүдийн олон том чулуу оношоор мэс заслын тасагт хэвтсэн. Төлөвлөгөөт журмаар ерөнхий унтуулгатайгаар мэс заслын тасагт цөсний ерөнхий сувгийн гаж хөгжилтэй тохиолдлын хагалгааг анх удаа хийж нэвтрүүлсэн. Өмнө нь УКТЭ-т хийгддэг байсан хагалгаа.
 - Иргэн Д.Б, 11 настай, эрэгтэй, зүүн хөлийн шилбэний дунд хугарлыг 3/1 анх удаа мэс заслын тасагт далд аргаар рентген харалтын дор эвлүүлэн, уян хадаасаар бэхлэх мэс заслыг амжилттай хийсэн.
Хагалгааны үр дүн: зөөлөн эдийн хөнөөл бага, өсөлтийн зон гэмтэхгүй, ор хоног бага, эдгэрэлт хурдан, ясны дефект бага үүсгэх
 - Иргэн О.Д 30 настай, эрэгтэй, мэс заслын тасагт баруун уушгины задрал, цээжний баруун хөндийд хий хуралт, баруун уушгины бүрэн авчил оношоор хэвтсэн. Цээжний хөндийд гуурс тавьж соруулсан боловч үр дүнгүй, уушги бүрэн сэргэхгүй байсан тул яаралтай журмаар ерөнхий унтуулгатай хагалгаа орсон. Хагалгаагаар баруун цээжний хөндийг нээж шалгахад уушги орой хэсэгтээ задарсан байсныг оёж битүүлсэн. Цээжний хөндийд гуурс байрлуулж, гуурсыг 2020-04-06 нд рентген харалтын дор авсан. Үр дүн 100%, өвчтөний биеийн байдал бүрэн эдгэрч эмнэлгээс гарсан.

БИД ЦААШИД:

- ISO 9001 олон улсын стандарт нэвтрүүлсэн байгууллага болох
- Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтэндээ дүгнэлт хийн улам сайжруулах бодлого, зорилтыг дэвшүүлэн ажиллах
- Эмч мэргэжилтнүүдийн ёс зүй, хандлагыг дээшлүүлэх чиглэлд үр дүнтэй ажил зохиох
- Ажилтнуудын нийгмийн асуудалд онцгойлон анхаарах
- ЭМТ-ийн өргөтгөл /төрөх тасаг/-ийн барилгыг дуусгаж, ашиглалтанд оруулах
- Яаралтай түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийх
- Эмч, эмнэлгийн ажилчдыг гадаад болон дотоодын мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтанд хамруулах
- Ажилчдын орон сууцжуулах эхлэлийг тавих
- Сантехникийн ил шугам сүлжээний засвар: *Төвийн барилга ашиглалтанд орсноос хойш 30 жил сантехник шугам сүлжээнд загвар огт хийгдээгүй. Шугам нь хэт элэгдэлд орсноос гагнуур хийх боломжгүй болж цоорхойнуудыг хаймар тавин боож аргацааж байна. 2017 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 70,254,093 төгрөгний далд шугамны засвар үйлчилгээ хийсэн.*
- Нийгмийн эрүүл мэндийн төвийн орон тоог нэмэгдүүлэх, бие даалгах:
Сүүлийн жилүүдэд үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор Нийгмийн эрүүл мэндийн төв, молекул биологийн лаборатори, нярайн эмгэгийн тасаг, гемодиализийн тасгийг шинээр нээж, цусны салбар банк, төвлөрсөн ариутгалын хэсэг, хими эмчилгээ, хөнгөвчлөх эмчилгээ, уламжлалт сэргээн засах болон мэс заслын

тусламж үйлчилгээг өргөтгөж байгаа учир бүтэц орон тоогоо шинэчлэн батлуулах

- ЭМТ-ийн өргөтгөл /төрөх тасаг/ 2020 онд ашиглалтанд ороход шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга эд хогшилын зардал 800 сая.төг, болон хүний нөөц, тогтмол зардлын санхүүжилтийг олох

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН,
ЭДИЙН ЗАСАГЧ Д.МӨНГӨНЦАЦРАЛ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА

Д.ШИНЭБАЯР